



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2022-2023 оны хөтөлбөр”-ийг батлах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 28 дугаар зүйлийн 28.8.2, Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 3.1, Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 5.1, 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”-ийг нэгдүгээр, “Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”-ийг хоёрдугаар, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг гуравдугаар, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг дөрөвдүгээр, “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг тавдугаар, “Ногоон ажлын байр хөтөлбөр”-ийг зургаадугаар, “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг долоодугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Дамбий/-т, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Л.Дашдэмбэрэл/-т, хэрэгжилтийг хангаж, хөтөлбөрийн үр дүнг улирал тутам тайлагнаж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дарга нарт даалгасугай.

3. Батлагдсан хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн гишүүд, нийгмийн түншлэлийн байгууллагуудад зөвлөсүгэй.

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,
САЙД



А.АРИУНЗАЯА

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2022 оны 02 сарын 11-ны өдрийн
1 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт



ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ ХӨТӨЛБӨР

Нэг. Зорилго

Ажил олоход хүндрэлтэй иргэн, ялангуяа нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны бөгөөд хөдөлмөрийн чадвартай гишүүнийг хөдөлмөрт бэлтгэж, ажлын байраар хангах, ажил олгогчдын оролцоог хангахад хөтөлбөрийн зорилго оршино.

Хоёр. Хамрах хүрээ

Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт дараах иргэн хамрагдана:

- 2.1. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны бөгөөд хөдөлмөрийн чадвартай иргэн;
- 2.2. Хорих ангиас суллагдсан иргэн;
- 2.3. Хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан иргэн;
- 2.4. Сургууль завсардсан хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхэд;
- 2.5. 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа иргэн.

Гурав. Хэрэгжүүлэх зарчим, удирдлага зохион байгуулалт

- 3.1. Хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага холбогдох арга хэмжээнд хамрагдахаар хандсан иргэнд болон хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдаж байгаа өрхийн хөдөлмөрийн насны бөгөөд хөдөлмөрийн чадвартай иргэнд хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээ (профайлинг) хийж, тэдгээрийн онцлог хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр хөтөлбөрт хамруулна.
- 3.2. Ажил, мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ, мэдээллийг хүргэх, ажил, мэргэжлээ сонгох болон хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах нөхцөлийн талаар зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах үйлчилгээг иргэнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу үзүүлнэ.
- 3.3. Хөтөлбөрийг удирдлага арга зүйгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, нэгдсэн зохицуулалтаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, зохион байгуулалтаар хөтөлбөрт нэр дурдсан харьяа байгууллагууд хангаж ажиллана.
- 3.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгдсэн удирдамж болон холбогдох үйл ажиллагааны зардлын жишиг хэмжээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд батална. Удирдамжид арга хэмжээний нарийвчилсан зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналт, хамрагдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тавигдах шалгуур, үзүүлэлтийг тодорхойлж, арга хэмжээний үйл явц, үе шат, үр дүн, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага болон бусад шаардлагатай зохицуулалтуудыг тусгасан байна.
- 3.5. Хөтөлбөрийн холбогдох арга хэмжээний тайлангийн маягт болон арга хэмжээ тус бүрийг хэрэгжүүлэхэд шаардагдах гэрээнүүдийн жишиг загварыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга батална. Тайлангийн маягтад хөтөлбөрт дурдсан арга хэмжээ тус бүрд хамрагдсан иргэний мэдээлэл, үр дүн,

зарцуулсан хөрөнгийн хэмжээг нарийвчилсан байдлаар тусгах бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны саналыг үндэслэн батална.

- 3.6. Энэ хөтөлбөрийн Эрхийн бичгийн сургалтын хөтөлбөрийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын саналыг үндэслэн Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын дарга батална.

Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээ

Ажил олоход хүндрэлтэй иргэн, ялангуяа нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны бөгөөд хөдөлмөрийн чадвартай гишүүнийг хөдөлмөрт бэлтгэж, ажлын байраар хангах, энэ ажлыг олгогчдын оролцоог хангах хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулна.



4.1. Хөдөлмөрт бэлтгэх

Ажил олоход хүндрэлтэй иргэн, ялангуяа нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны бөгөөд хөдөлмөрийн чадвартай гишүүнийг дараах хэлбэрээр хөдөлмөрт бэлтгэж, ажлын байраар хангана.

4.1.1. Ажлын байрны харилцаа, сэтгэл зүйн сургалт зохион байгуулах:

4.1.1.1. Хувь хүний төлөвшил, сэтгэлгээг хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэхийн ач холбогдол болон түүний харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан шатны мэдлэг олгох хүрээнд ажлын байран дахь харилцааны ур чадвар, сэтгэл зүйн сургалтыг зохион байгуулна;

4.1.1.2. Тус арга хэмжээг хөдөлмөрийн хувийн бирж болон мэргэжлийн холбогдох байгууллагаар гэрээний дагуу зохион байгуулж болох бөгөөд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар холбогдох төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллагатай хамтран арга хэмжээний сургалтын хөтөлбөр, агуулгыг боловсронгуй болгон хөгжүүлж, сургагч багш, байгууллагыг чадавхжуулж ажиллана.

4.1.2. Ажилд зуучлах уулзалтад бэлтгэх:

4.1.2.1. Иргэнийг ажилд зуучлахад нэн шаардлагатай ахуйн хэрэглээний тусламж, дэмжлэгийг үзүүлэх хүрээнд ажилд зуучлахад бэлтгэнэ. Арга хэмжээнд тухайн иргэнийг бичиг баримтжуулах, наад захын хэрэгцээт ахуйн хэрэглээний барааг худалдан авах болон бусад шаардлагатай зүйлээр хангах бөгөөд зардлын жишиг хэмжээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд тогтооно.

Энэ хөтөлбөрийн 4.1.1 болон 4.1.2-т заасан арга хэмжээ тус бүрд хамрагдах нийт хүний 70 хувиас багагүй хэмжээнд энэ хөтөлбөрийн 2.1-т заасан хүнийг хамруулна.

4.2. Хөдөлмөр эрхлэлтийн сургалт

Аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь энэ хөтөлбөрийн 2 дугаар бүлэгт заасан иргэнийг богино хугацаанд мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх хөдөлмөр эрхлэлтийн дараах хэлбэрийн сургалтад хамруулна.

4.2.1. Хөдөлмөр эрхлэлтийн танхимын сургалт зохион байгуулах:

4.2.1.1. Хөдөлмөрийн зах зээлийн болон ажил олгогчийн эрэлтэд нийцүүлэн иргэний суралцах мэргэжлийн чиглэл, боломжийн талаарх хүсэлтэд үндэслэн мэргэжлийн ур чадварыг богино хугацаанд эзэмшүүлэх хөдөлмөр эрхлэлтийн танхимын сургалтыг зохион байгуулна.

Сургалтыг нийслэлийн төвийн 6 дүүрэгт Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар "Эрхийн бичгийн сургалтын хөтөлбөр"-ийн дагуу, 21 аймаг болон алслагдсан 3 дүүрэгт аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн дагуу зохион байгуулна;

4.2.1.2. Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар, аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага мэргэжлийн болон давтан сургалтыг эрх бүхий сургалтын байгууллагуудаас /Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага, мэргэжлийн сургалтын байгууллага/ сонгон шалгаруулж, гэрээ байгуулж ажиллана. Сургалтын онол, дадлагын хичээлийн харьцаа 30/70 байна;

4.2.1.3. Сургалтыг чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрөөр зохион байгуулах бөгөөд үргэлжлэх хугацаа нь 1-6 долоо хоног, 7 хоногт 36-гаас доошгүй цагийн хөтөлбөртэй байна.



4.2.2. Хөдөлмөр эрхлэлтийн үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулах:

4.2.2.1. Хөдөлмөрийн зах зээлийн болон ажил олгогчийн эрэлтэд нийцүүлэн иргэний суралцах мэргэжлийн чиглэл, боломжийн талаарх хүсэлтэд үндэслэн мэргэжлийн ур чадварыг богино хугацаанд эзэмшүүлэх хөдөлмөр эрхлэлтийн үйлдвэрлэл дээрх сургалтыг зохион байгуулна;

4.2.2.2. Сургалтаар ажил олгогчийн үйлдвэрлэл, ажлын байранд тухайн иргэнийг шинэ мэргэжил, ур чадвар эзэмшүүлэх, мэргэшүүлэх, ажиллуулах зорилгоор дагалдуулан сургана;

4.2.2.3. Сургалтыг нийслэлийн төвийн 6 дүүрэгт Нийслэлийн хөдөлмөр, эрхлэлтийн газар, 21 аймаг болон алслагдсан 3 дүүрэгт аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага орон нутгийн хөдөлмөрийн зах зээл дэх эрэлтийн дагуу зохион байгуулна;

4.2.2.4. Сургалтын онол, дадлагын хичээлийн харьцаа 20/80 байна;

4.2.2.5. Сургалтын дадлагын хэсгийг аж ахуйн нэгж буюу ажил олгогч, онолын хэсгийг энэ хөтөлбөрийн 4.2.2.3-т дурдсан зохион байгуулагч байгууллага мэргэжлийн сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулна;

4.2.2.6. Сургалтын хугацааг хувь хүний эрэлт, ажил олгогчийн хэрэгцээ, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох чадамжийн нэгжийн хөтөлбөрт үндэслэн уян хатан тогтоож болох бөгөөд нийт үргэлжлэх хугацаа нь 3-6 долоо хоног, 7 хоногийн сургалт нь 36-гаас доошгүй цагийн хөтөлбөртэй байна;

4.2.2.7. Аж ахуйн нэгж 5-аас дээш хүнийг дадлагажуулан ажиллуулах тохиолдолд 80-аас доошгүй хувийг ажлын байраар хангана;

4.2.2.8. Аж ахуйн нэгжид 10.0 сая хүртэл төгрөгийн сургалтын зардлыг үр дүнгийн гүйцэтгэлд үндэслэн зардлын жишгийн дагуу нөхөн олгоно;

4.2.2.9. Сургалтын үйл ажиллагаанд зарцуулагдах ажлын байр, цахилгаан, багаж, тоног төхөөрөмж зэрэг материаллаг болон материаллаг бус зардлыг аж ахуйн нэгж өөрөө хариуцна;

4.2.2.10. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээс зохион байгуулах сургалтын зардлыг холбогдох бичиг баримтыг үндэслэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас тухай бүр санхүүжүүлнэ.

Энэ хөтөлбөрийн 4.2.1, 4.2.2-т заасан арга хэмжээ тус бүрд хамрагдах нийт хүний 60 хувиас багагүй хэмжээнд энэ хөтөлбөрийн 2.1-т заасан хүнийг хамруулах бөгөөд тэдгээрт "Мэргэжлийн сургалтаар чадамж, мэргэжил эзэмшсэн төгссөгч иргэдийн мэргэшлийн түвшинг үнэлэх, баталгаажуулах журам"-ын дагуу ур чадварын шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулж, "Чадамжийн гэрчилгээ" олгоно. Иргэн өөрөө хүсвэл мэргэжлийн зэрэг олгох шалгалтад хамрагдаж болно.

4.3. Нийгмийн хариуцлагатай ажил олгогчийг шалгаруулах

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар энэ хөтөлбөрийн 2 дугаар бүлэгт заасан иргэнийг ажлын байраар хангаж, хөдөлмөр эрхлэх, орлогоо нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлсэн нийгмийн хариуцлагатай ажил олгогчийг шалгаруулах арга хэмжээг дараах аж ахуйн нэгж, байгууллагуудын хүрээнд улсын хэмжээнд зохион байгуулж, нийтэд мэдээлж, өргөмжилнө.

4.3.1. Төрийн байгууллагуудын нийгмийн хариуцлагыг урамшуулах:

4.3.1.1. Төрийн байгууллагын нийгмийн хариуцлагыг урамшуулах хүрээнд өрхийн аж ахуй, нөхөрлөл, хоршоо, үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг төрийн худалдан авалтаар дэмжиж, төрийн үйлчилгээний болон бусад ажлын байранд энэ хөтөлбөрийн 2 дугаар бүлэгт заасан хүнийг авч ажиллуулсан төрийн байгууллагыг шалгаруулж, өргөмжилнө.

4.3.2. Нийгмийн хариуцлагатай хувийн хэвшлийг шалгаруулж, өргөмжлөх:

4.3.2.1. Хувийн хэвшлийн нийгмийн хариуцлагыг урамшуулах хүрээнд ажилчдын цалин урамшууллыг өрхийн амьжиргааг хангах түвшинд хүргэж, нэмэгдүүлж байгаа, энэ хөтөлбөрийн 2 дугаар бүлэгт заасан хүнийг ажилд авч ажлын байраар хангасан, цагийн ажлыг нэмэгдүүлсэн болон бусад дэмжлэг үзүүлсэн аж ахуйн нэгжийг шалгаруулж, өргөмжилнө.

4.3.3. Нийгмийн хариуцлагатай нөхөрлөл, хоршоог шалгаруулж, өргөмжлөх:

4.3.3.1. Ажлын байр бий болгож, албан бус салбараас албан салбарт шилжиж, ажлын байраа нөхөрлөл, хоршооны хэлбэрт шилжүүлэн ажиллаж байгаа, энэ хөтөлбөрийн 2 дугаар бүлэгт заасан хүнийг ажлын байраар хангаж, хоршиж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа нөхөрлөл, хоршоог шалгаруулж, өргөмжилнө.

Энэ арга хэмжээг ажил олгогчдын эрх ашгийн төлөө ажилладаг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

Тав. Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн

Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар гаргахаас гадна хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага нь бүх шалгуур үзүүлэлтийг нас, хүйс, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр тус бүрээр нарийвчлан гаргаж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд сар бүр тайлагнана.

5.1. Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт



Түвшин	Үзүүлэлт	Баталгааж их эх сурвалж	Суурь түвшин (2021)	Хүрэх түвшин (2022)	Хүрэх түвшин (2023)
Гарцын шалгуур үзүүлэлт (output)	Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд хамрагдсан хүний тоо, арга хэмжээ тус бүрээр, зарцуулсан хөрөнгө	ХХҮЕГ-ын сарын, жилийн тайлан	2000 хүн	7000 хүн	8000 хүн
	Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдсан хүний тоо, арга хэмжээ тус бүрээр, зарцуулсан хөрөнгө		1243 хүн	2900 хүн	3500 хүн
	"Чадамжийн гэрчилгээ" авсан хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдсан хүний тоо		-	2320 хүн	2800 хүн
	Нийгмийн хариуцлагатай ажил олгогчийн тоо		-	Төрийн 20, Хувийн хэвшлийн 50 Нөхөрлөл, хоршооны 40	Төрийн 20, Хувийн хэвшлийн 60, Нөхөрлөл, хоршооны 40
Үр дүнгийн шалгуур үзүүлэлт (outcome)	Хөтөлбөрт хамрагдсанаар тогтмол ажлын байртай болсон, НДШ 6 сараас дээш хугацаагаар төлсөн хүний тоо	Мөшгөх судалгааны тайлан (хөтөлбөр хэрэгжиж дууссанаас хойш 1 жилийн дотор)		Хөтөлбөрт хамрагдах үеийн нөхцөл байдлын мэдээлэл	Суурь мэдээлэл дээр үндэслэн нэмэгдсэн ажлын байрны тоо

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2022 оны 11 сарын 11-ны өдрийн
1 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт



АЖ АХУЙ ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Нэг. Зорилго

Цар тахлын үед үйлдвэрлэл, үйлчилгээ, мал аж ахуй эрхлэгчдэд үйл ажиллагаагаа сэргээхэд чиглэсэн барьцаагүй, хүүгүй, эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлж, ажлын байр бий болгох, хадгалах, хамгаалах санаачилгыг дэмжиж иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Хоёр. Хамрах хүрээ

Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрт дараах иргэн, өрх, аж ахуйн нэгж, байгууллага хамрагдана:

Иргэн:

- 2.1. Ажилгүй иргэн;
- 2.2. Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн.

Өрх:

- 2.3. Хөдөө, орон нутагт шилжин суурьших хүсэлтэй малчин өрх;
- 2.4. Малгүй болон цөөн малтай өрх.

Аж ахуйн нэгж, байгууллага:

- 2.5. Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч;
- 2.6. Нөхөрлөл, хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч.

Гурав. Хэрэгжүүлэх зарчим, удирдлага зохион байгуулалт

- 3.1. Хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага холбогдох арга хэмжээнд хамрагдахаар хандсан иргэнд хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээ (профайлинг) хийж, тэдгээрийн онцлог хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр хөтөлбөрт хамруулна.
- 3.2. Ажил, мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ, мэдээллийг хүргэх, ажил, мэргэжлээ сонгох болон хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах нөхцөлийн талаар зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах болон ажилд зуучлах үйлчилгээг иргэнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу үзүүлнэ.
- 3.3. Хөтөлбөрийг удирдлага арга зүйгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, нэгдсэн зохицуулалтаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, зохион байгуулалтаар хөтөлбөрт нэр дурдсан харьяа байгууллагууд хангаж ажиллана.
- 3.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгдсэн удирдамж болон холбогдох үйл ажиллагааны зардлын жишиг хэмжээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд батална. Удирдамжид арга хэмжээний нарийвчилсан зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналт, хамрагдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тавигдах шалгуур, үзүүлэлтийг тодорхойлж, арга хэмжээний үйл явц, үе шат, үр дүн, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага болон бусад шаардлагатай зохицуулалтуудыг тусгасан байна.
- 3.5. Хөтөлбөрийн холбогдох арга хэмжээний тайлангийн маягт болон арга хэмжээ тус бүрийг хэрэгжүүлэхэд шаардагдах гэрээнүүдийн жишиг загварыг Хөдөлмөр,

халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга батална. Тайлангийн маягтад хөтөлбөрт дурдсан арга хэмжээ тус бүрд хамрагдсан иргэний мэдээлэл, үр дүн, зарцуулсан хөрөнгийн хэмжээг нарийвчилсан байдлаар тусгах бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны саналыг үндэслэн батална.

- 3.6. Энэ хөтөлбөрт тусгасан санхүүгийн дэмжлэгийг Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ын хүрээнд хэрэгжүүлж, зохион байгуулна.

Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээ

Үйлдвэрлэл, үйлчилгээ, мал аж ахуй эрхлэгчдэд үйл ажиллагаагаа сэргээхэд чиглэсэн барьцаагүй, хүүгүй, эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлж, ажлын байр бий болгох, хадгалах, хамгаалах санаачилгыг дэмжиж иргэдийн орлогыг нэмэгдүүлэх хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулна.



4.1. Иргэн, аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг олгох

Ажлын байр шинээр бий болгох, хадгалах, хамгаалахад чиглэсэн аж ахуй эрхлэх үйл ажиллагааны төсөлд зориулж иргэн, аж ахуйн нэгжид барьцаагүй, хүүгүй, 100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгох, аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.1.1. Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох:

- 4.1.1.1. Аж ахуй, бичил бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээ¹ эрхлэх хүсэлтэй 30 ба түүнээс дээш насны энэ хөтөлбөрийн 2.1, 2.2-т заасан хүний боловсруулсан ажлын байр бий болгох, хадгалах, хамгаалах зорилготой төслийг хэрэгжих үндэслэлийг харгалзан шалгаруулж, 10.0 хүртэл сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийг 36 сарын хугацаатайгаар нэг удаа олгоно;
- 4.1.1.2. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь жил бүрийн 4 болон 9 дүгээр сард төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ба санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлт гаргасан иргэдийг бүртгэн төслүүдийг хүлээн авч сонгон шалгаруулна;
- 4.1.1.3. Төслийг аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын даргын тушаалаар байгуулсан ажлын хэсэг сонгон шалгаруулах ба сонгон шалгаруулалтын үе шат бүрийг ил тод, нээлттэй иргэд, оролцогчдын оролцоог хангасан байдлаар зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд төслийн санал ирүүлсэн иргэн өөрийн төслийг ажлын хэсэг болон ажлын хэсгийн үйл ажиллагааг хянаж байгаа иргэдийн төлөөлөлд танилцуулж болно;
- 4.1.1.4. Санхүүгийн дэмжлэг авахаар шалгарсан иргэнтэй тухайн аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага гэрээ байгуулж, эргэн төлөлтийг хариуцан ажиллана.

4.1.2. Финтекээр богино хугацааны эргэлтийн хөрөнгийн дэмжлэг олгох:

- 4.1.2.1. Санхүүгийн дэмжлэгийг зайнаас, түргэн шуурхай, хүндрэл чирэгдэлгүйгээр олгох хүрээнд 1.0 хүртэл сая төгрөгийн эргэн төлөх нөхцөлтэй богино хугацааны эргэлтийн хөрөнгийн дэмжлэгийг

¹ "үйлчилгээ" гэдэгт худалдааны үйл ажиллагаа эрхэлж байгааг хамааруулахгүй.

туршилтын байдлаар финтек технологи (fintech) ашиглан орчин үеийн шинэлэг, цахим хэлбэрээр автоматжуулан иргэн, аж ахуйн нэгжид олгоно;

- 4.1.2.2. Арга хэмжээнд энэ хөтөлбөрийн 2.2, 2.5, 2.6-т заасан иргэн, аж ахуйн нэгж Зээлийн мэдээллийн нэгдсэн санд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй ажлын байр бий болгох, хадгалах, хамгаалах зорилгоор хамрагдаж болно;
- 4.1.2.3. Богино хугацааны эргэлтийн хөрөнгийн дэмжлэгийг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа туршлага бүхий санхүүгийн байгууллагаар дамжуулан олгох бөгөөд уг дамжуулан зээлдүүлэх байгууллагыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сонгон шалгаруулж, гэрээ байгуулж ажиллана;
- 4.1.2.4. Богино хугацааны эргэлтийн хөрөнгийн дэмжлэгийг иргэнд эхний ээлжинд 400.0 хүртэл мянган төгрөгөөс эхлэн 1 сар хүртэл хугацаатай олгох бөгөөд хугацаандаа зээлийг эргэн төлсөн тохиолдол бүрд зээл авах боломжит хэмжээг нэмэгдүүлж, 1.0 хүртэл сая төгрөгт хүргэнэ;
- 4.1.2.5. Богино хугацааны эргэлтийн хөрөнгийн дэмжлэг нь барьцаагүй, хүүгүй, 100 хувь эргэн төлөх нөхцөлтэй байх ба зээлийн 1 удаагийн шимтгэлийг зээлдэгч хариуцна.
- 4.1.3. Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах:
- 4.1.3.1. Энэ хөтөлбөр болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдаж, санхүүгийн дэмжлэг, жижиг зээл авахаар төсөл боловсруулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтэд үндэслэн аж ахуй эрхлэлтийн сургалтыг санхүүгийн дэмжлэг, жижиг зээлийн өмнө ба дараа зохион байгуулна;
- 4.1.3.2. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь аж ахуй эрхлэлтийн сургалтаар мэргэшсэн сургагч багшийн эрх бүхий ажилтантай бол тухайн ажилтнаар эсвэл сургалтын байгууллагатай гэрээний үндсэн дээр сургалтыг зохион байгуулна;
- 4.1.3.3. Сургалтын байгууллагыг аж ахуй эрхлэлтийн эрх бүхий сургалтын байгууллагын жагсаалтаас сонгох бөгөөд жагсаалтыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран гаргана;
- 4.1.3.4. Аж ахуй эрхлэлтийн сургалтын үргэлжлэх хугацаа ажлын 3 хоног байх бөгөөд жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгохоос өмнө 1 хоног, олгосны дараа 2 хоног байна. 3 хоногийн сургалт нь 21 академик цагаас доошгүй хөтөлбөртэй байна;
- 4.1.3.5. Сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулж болох бөгөөд бүх нийтийн болон амралтын өдрүүдэд зохион байгуулахгүй.



4.2. Малчдыг малжуулах

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар цөөн малтай болон малгүй иргэдийг ажлын байртай болгох, ажлын байрыг хадгалах хүрээнд эргэн төлөгдөх нөхцөлтэй малчдыг малжуулах санхүүгийн дэмжлэгийг олгох, гэрээт малчин өрхийг ажилд зуучлах арга хэмжээг дараах байдлаар зохион байгуулна.

4.2.1. Малгүй болон цөөн малтай малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох:

4.2.1.1. 21 аймаг, нийслэлийн алслагдсан 3 дүүргийн хөдөлмөрийн чадвартай 18-45 насны 2-оос доошгүй гишүүнтэй, малгүй болон бог малд шилжүүлснээр 150 хүртэл толгой малтай малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамруулна;

4.2.1.2. Арга хэмжээг тухайн аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага зохион байгуулна;

4.2.1.3. Арга хэмжээнд малгүй болон 150 хүртэл толгой бог малтай мал маллах хүсэлтэй өрхийг хамруулан 5.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг мал худалдан авах зориулалтаар зарцуулна;

4.2.1.4. Санхүүгийн дэмжлэгийг мал худалдан авч өгснөөс хойш 36 сарын дотор хуваарийн дагуу 100 хувь эргүүлэн мөнгөн хэлбэрээр төлнө;

4.2.1.5. Арга хэмжээнд хамрагдах малчин өрхийг сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлийн саналыг үндэслэн аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага сонгож, гэрээ байгуулж ажиллах бөгөөд гэрээнд эргэн төлөлтийн хуваарийг иргэний хүсэлтийг үндэслэн тогтоож, хавсаргана;

4.2.1.6. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага мал худалдан авч өгөх үйл ажиллагааг хуулийн дагуу нээлттэй, ил тод зохион байгуулах бөгөөд худалдан авч байгаа малын үнэ зах зээлийн дундаж үнээс илүүгүй байна.

4.2.2. Өрхийг гэрээт малчнаар ажиллуулах арга хэмжээ:

4.2.2.1. Улаанбаатар хот, аймгийн төвөөс хөдөөд шилжин суурьшиж, мал маллах хүсэлтэй өрхийг гэрээт малчнаар ажилд зуучилж, 2 жилийн хугацаанд тогтвортой ажиллуулах нөхцөлтэй малжуулах санхүүгийн дэмжлэг олгож болно;

4.2.2.2. Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага Улаанбаатар хотод оршин сууж байгаад хөдөөд, аймгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага аймгийн төвд оршин сууж байгаад хөдөөд шилжин суурьшиж, мал маллах хүсэлтэй өрхийг гэрээт малчнаар ажилд зуучилж, 2 жилийн хугацаанд тогтвортой ажлын байраар хангаж, орлоготой болгох арга хэмжээг зохион байгуулна;

4.2.2.3. Гэрээт малчин өрхийг ажиллуулах малчин нь бог малд шилжүүлснээр 600 болон түүнээс дээш тооны малтай, гэрээгээр мал маллах өрхийг авч ажиллуулах хүсэлт гаргасан малчин байна;

4.2.2.4. Гэрээт малчин өрх нь 18-59 насны хөдөлмөрийн чадвартай 2-оос доошгүй гишүүнтэй, гэр бүлээрээ хөдөөд шилжин суурьшиж, 2-оос доошгүй жил гэрээт малчнаар ажиллах нөхцөлийг зөвшөөрч хүсэлт гаргасан, тухайн хаягтаа 1 жилийн хугацаанд оршин суусан байна;




- 4.2.2.5. Ажил олгогч малчин нь гэрээт малчин өрхийн 2 гишүүнийг сард хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээгүүр үндсэн цалинтай байхаар харилцан тохиролцож, Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн гэрээ байгуулж, цалинжуулж ажиллуулна;
- 4.2.2.6. Ажил олгогч малчин болон гэрээт малчин өрхийн гишүүдийн нийгмийн даатгалын шимтгэлийг тухай бүр тухайн жилд хуваарилагдсан хөрөнгөөс нөхөн төлж хөнгөлөлт үзүүлнэ;
- 4.2.2.7. Гэрээт малчин өрхийн гишүүд нь тухайн оршин суух газартаа түр шилжүүлэг хийлгэх болон нийгмийн даатгалын дэвтэр авах зэрэг холбогдох бусад зардлыг өөрөө хариуцна;
- 4.2.2.8. Гэрээт малчин өрхийн орон нутаг руу нүүх зардлыг суурьших сумын замын уртаас хамааруулан тооцож, 50-200 км-т 150.0 мянган төгрөг, 201-350 км-т 350.0 мянган төгрөг, 351-500 км-т 500.0 мянган төгрөгийн дэмжлэгийг нэг удаа олгоно;
- 4.2.2.9. Гэрээт малчин өрхийн хүсэлтээр гэрээт малчнаар 2 жилийн хугацаанд тогтвортой ажиллуулах нөхцөлтэйгөөр малжуулах санхүүгийн дэмжлэг олгож болно;
- 4.2.2.10. Гэрээт малчин өрхөд 4.0 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг мал худалдан авах зориулалтаар зарцуулах ба 24 сарын хугацаанд эргэн төлөх нөхцөлтэй байна;
- 4.2.2.11. Гэрээт малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгохыг гэрээт малчин өрхийг ажиллуулах ажил олгогч малчин зөвшөөрсөн байх ба энэ тухай гэрээт малчин өрхийн 2 гишүүнтэй байгуулах гэрээнд тусгана. Ажил олгогч малчин мал худалдан авч өгөхөд дэмжлэг үзүүлж болно;
- 4.2.2.12. Гэрээт малчин өрх малчинтай байгуулсан гэрээг өөрийн буруугаас болж цуцлах тохиолдолд малжуулах санхүүгийн дэмжлэгийг буцаан төлж барагдуулна. Харин малчин ажил олгогчийн буруутай үйлдлээс болж гэрээ цуцлагдах тохиолдолд аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нөхцөл байдлыг судалж, гэрээний дагуу төлж барагдуулах, эсхүл тухайн цаг үед шууд төлж барагдуулах талаар шийдвэр гаргана. Энэ тухайг холбогдох гэрээнүүдэд тусгана.
- 4.2.3. Мал маллах болон малын ашиг шим боловсруулах сургалт зохион байгуулах:
- 4.2.3.1. Малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрх болон гэрээт малчин өрхөд мал маллах арга ухааны болон малын ашиг шимийг боловсруулах сургалт (мах, сүү цагаан идээ, ноос, арьс шир боловсруулах г.м), туршлага солилцох уулзалт зохион байгуулах зэрэг дэмжлэг, туслалцааг үзүүлнэ;
- 4.2.3.2. Энэ арга хэмжээний нийт зардал нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас энэ хөтөлбөрийн малжуулах санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр хуваарилсан нийт хөрөнгийн 8 хувиас ихгүй байна;



4.2.3.3. Арга хэмжээг аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага зохион байгуулах эрх бүхий мэргэшсэн сургалтын байгууллагыг сонгож, гэрээ байгуулан зохион байгуулна;

4.2.3.4. Сургалтыг мал маллагаа, аж ахуй эрхлэлтийн сургалтаар мэргэшсэн эрх бүхий сургагч багшаар гэрээний дагуу зохион байгуулж болно;

4.2.3.5. Туршлагатай сайн малчдаас суралцах, туршлага солилцох, дэлгэрүүлэх зорилготой уулзалт, хэлэлцүүлгийн төлөвлөгөөг хуваарилагдсан төсөвт багтаан тухайн аймаг, алслагдсан 3 дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөр батлуулан зохион байгуулж болно.



4.3. Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон эргэн төлөгдөх санхүүгийн болон бусад дэмжлэг, жижиг зээл авсан иргэдэд бараа, бүтээгдэхүүн борлуулахад нь дэмжлэг үзүүлэх болон ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.3.1. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага иргэн, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг борлуулах цэг²-ийг ажиллуулна.

4.3.2. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага үйлдвэрлэл, үйлчилгээ³-ний зориулалтаар 6 болон түүнээс дээш сарын хугацаагаар ажлын байр түрээслэн үйл ажиллагаа явуулж байгаа, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг авсан иргэн, аж ахуйн нэгжид түрээсийн гэрээ, холбогдох баримт бичиг, нөхцөл байдлыг газар дээр нь үнэлсэн үнэлгээнд үндэслэн тухайн жилийн 6 хүртэл сарын хугацааны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт⁴-ийг төлбөр төлсөн баримтаар нөхөн олгоно.

4.3.3. Түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг холбогдох баримт бичиг, түрээсийн гэрээг үндэслэн нөхцөл байдлыг газар дээр нь үнэлгээ хийж, тодорхойлсны үндсэн дээр улиралд нэг удаа нөхөн олгоно. Түрээсийн төлбөрийг нөхөн олгохдоо тухайн төлбөрийг төлсөн баримтыг үндэслэнэ.

4.3.4. Ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг авсан иргэн, аж ахуйн нэгж тухайн иргэдийн ажлын байрыг хадгалах үүрэг хүлээх бөгөөд энэ тухайг холбогдох гэрээнд тусгаж, зохион байгуулагч талтай байгуулна.

4.3.5. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг зарж борлуулахад чиглэсэн үзэсгэлэн, яармагийг зохион байгуулна.

4.3.6. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар үндэсний бүтээгдэхүүнийг гадаад орнуудад гаргаж, борлуулалт хийдэг байгууллагуудаар дамжуулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдэд хамрагдсан иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг гадаад орнуудад борлуулахад зохион байгуулалтын дэмжлэг үзүүлнэ.

4.3.7. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн болон бусад дэмжлэг авсан иргэн, аж

² Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан "Борлуулалтын цэг ажиллуулахад зарцуулах нэг сарын зардлын дээд хэмжээ"-нээс хэтрүүлэхгүйгээр энэхүү цэгийг ажиллуулна.

³ "Үйлчилгээ" гэдэгт худалдааны үйл ажиллагаа эрхэлж байгааг хамааруулахгүй.

⁴ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан "Түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх нэг сарын зардлын хэмжээ"-нээс хэтрүүлэхгүй байна.

ажуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор улсын хэмжээнд хамгийн өндөр ашиглалт хандалттай 2 хүртэлх хувийн хэвшлийн худалдааны цахим хуудастай хамтарч ажиллана.

4.4. Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ

- 4.4.1. Ажил олгогчоос ажил олоход хүндрэлтэй иргэнийг авч ажиллуулахтай холбоотой гарсан зардлын тодорхой хэсгийг нөхөн төлөх, тухайн иргэнийг ажлын байранд нь тогтвортой ажиллуулахыг урамшуулах зорилго бүхий ажил олгогчийг дэмжих арга хэмжээг зохион байгуулна.
- 4.4.2. “Ажил олгогч” нь улсын бүртгэлийн болон татвар, нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй, нэг буюу түүнээс дээш ажилтныг хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр авч байнгын ажлын байранд ажиллуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөл, хоршооны удирдлага байна.
- 4.4.3. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлэн, ажил идэвхтэй хайж байгаа боловч 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа иргэнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар байнгын ажлын байраар хангасан ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг бий болгосон байнгын ажлын байраар тооцож, ажил олгогчид нэг удаа олгоно.
- 4.4.4. Хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан иргэнийг үйлдвэрлэл дээрээ дадлагажуулан үндсэн ажилтнаар нэг жилээс доошгүй хугацаагаар үргэлжлүүлэн байнгын ажлын байраар хангаж байгаа ажил олгогчид дадлагын хугацааны сургалтын зардлыг нөхөн олгож, нэг жилийн цалин хөлстэй тэнцэх хэмжээний санхүүгийн дэмжлэгийг бий болгосон байнгын ажлын байраар тооцож, ажил олгогчид нэг удаа олгоно.
- 4.4.5. Ажил олгогч энэ хөтөлбөрийн 4.4.3, 4.4.4-т заасан иргэнийг ажлын байраар хангах тухайгаа тухайн иргэний харьяалах аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад мэдэгдэн гэрээг байгуулж, холбогдох урамшууллыг авна.
- 4.4.6. Ажил олгогч нь ажлын байраар хангасан иргэнийг нийгмийн даатгалд хамруулж, цалин, хөлсийг олгон шаардлагатай баримт бичгийг бүрдүүлнэ.



Тав. Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн

Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар гаргахаас гадна хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага нь бүх шалгуур үзүүлэлтийг нас, хүйс, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр тус бүрээр нарийвчлан гаргаж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд сар бүр тайлагнана.

5.1. Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт

Түвшин	Үзүүлэлт	Баталгаажих эх сурвалж	Суурь түвшин (2021)	Хүрэх түвшин (2022)	Хүрэх түвшин (2023)
Гарцын шалгуур үзүүлэлт (output)	Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамрагдсан хүний тоо, зарцуулсан болон эргэн төлөгдсөн хөрөнгийн хэмжээ	ХХҮЕГ-ын сарын, жилийн тайлан	1190 иргэн	1500 иргэн	2000 иргэн
	Финтекээр богино хугацааны эргэлтийн хөрөнгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамрагдсан хүний тоо, зарцуулсан болон эргэн төлөгдсөн хөрөнгийн хэмжээ		-	3500 иргэн	4000 иргэн
	Аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдсан хүн, аж ахуйн нэгжийн тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ, хөтөлбөр бүрээр		4272 иргэн	3000 иргэн	3500 иргэн
	Малчдыг малжуулах санхүүгийн дэмжлэгийг авсан хүний тоо, зарцуулсан болон эргэн төлөгдсөн хөрөнгийн хэмжээ		363 өрх 672 иргэн	1100 өрх 2750 иргэн	1250 өрх 3125 иргэн
	Гэрээт малчнаар ажилд зуучлагдсан өрх, хүний тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ		-	110 өрх	120 өрх
	Малжуулах санхүүгийн дэмжлэгийг авсан гэрээт малчин өрх, хүний тоо, зарцуулсан болон эргэн төлөгдсөн хөрөнгийн хэмжээ		-	110 өрх	120 өрх



	Борлуулалтын дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамрагдсан хүн, аж ахуйн нэгжийн тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ		942 иргэн	-	-
	Түрээсийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамрагдсан хүн, аж ахуйн нэгжийн тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ		-	1500 иргэн	1600 иргэн
	Гадаад дотоодын үзэсгэлэн яармагт хамрагдсан хүн, аж ахуйн нэгжийн тоо		-		
	Ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан ажил олгогчийн болон иргэний тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ		90 Ажил олгогч	220 2021 оны гэрээ Ажил олгогч	270 Ажил олгогч
	Ажил олгогчид санхүүгийн дэмжлэг олгох /асрамжийн газраас гарсан, хорих ангиас суллагдсан иргэнийг ажлын байраар хангасан/		-	50 Ажил олгогч	60 Ажил олгогч
Үр дүнгийн шалгуур үзүүлэлт (outcome)	Хөтөлбөрт хамрагдсанаар тогтмол ажлын байртай болсон, НДШ 6 сараас дээш хугацаагаар төлсөн хүний тоо	Мөшгөх судалгааны тайлан (хөтөлбөр хэрэгжиж дууссанаас хойш 1 жилийн дотор)		Хөтөлбөрт хамрагдах үеийн нөхцөл байдлын мэдээлэл	Суурь мэдээлэл дээр үндэслэн нэмэгдсэн ажлын байрны тоо



Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2022 оны 12 сарын 17-ны өдрийн
1 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт



ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Нэг. Зорилго

Залуучуудад хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх болон аж ахуй эрхлэх өөрөө өөртөө ажлын байр бий болгох, бүтээлч, шинэлэг санал, санаачилгыг дэмжихэд хөтөлбөрийн зорилго оршино.

Хоёр. Хамрах хүрээ

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт дараах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хамрагдана:

- 2.1. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан Монгол Улсын иргэн;
- 2.2. 15-34 насны ажилгүй, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа залуучууд;
- 2.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид, их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага төгсөөд 3 хүртэл жил болж байгаа, эзэмшсэн мэргэжлээрээ ажилласан туршлагагүй ажил хайж буй залуучууд;
- 2.4. Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх "Оролцоо" төслийн төгсөгчид;
- 2.5. Их, дээд сургууль болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага;
- 2.6. Аж ахуйн нэгж, байгууллага.

Гурав. Хэрэгжүүлэх зарчим, удирдлага зохион байгуулалт

- 3.1. Хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага холбогдох арга хэмжээнд хамрагдахаар хандсан иргэнд хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээ (профайлинг) хийж, тэдгээрийн онцлог хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр хөтөлбөрт хамруулна.
- 3.2. Ажил, мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ, мэдээллийг хүргэх, ажил, мэргэжлээ сонгох болон хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах нөхцөлийн талаар зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах болон ажилд зуучлах үйлчилгээг иргэнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу үзүүлнэ.
- 3.3. Хөтөлбөрийг удирдлага арга зүйгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, нэгдсэн зохицуулалтаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, зохион байгуулалтаар хөтөлбөрт нэр дурдсан харьяа байгууллагууд хангаж ажиллана.
- 3.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгдсэн удирдамж болон холбогдох үйл ажиллагааны зардлын жишиг хэмжээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд батална. Удирдамжид арга хэмжээний нарийвчилсан зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналт, хамрагдах иргэн, аж ахуйн нэгж байгууллагад тавигдах шалгуур, үзүүлэлтийг тодорхойлж, арга хэмжээний үйл явц, үе шат, үр дүн, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага болон бусад шаардлагатай зохицуулалтуудыг тусгасан байна.
- 3.5. Хөтөлбөрийн холбогдох арга хэмжээний тайлангийн маягт болон арга хэмжээ тус бүрийг хэрэгжүүлэхэд шаардагдах гэрээнүүдийн жишиг загварыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга батална. Тайлангийн маягтад

хөтөлбөрт дурдсан арга хэмжээ тус бүрд хамрагдсан иргэний мэдээлэл, үр дүн, зарцуулсан хөрөнгийн хэмжээг нарийвчилсан байдлаар тусгах бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны саналыг үндэслэн батална.

- 3.6. Энэ хөтөлбөрт тусгасан санхүүгийн дэмжлэгийг Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ын хүрээнд хэрэгжүүлж, зохион байгуулна.



Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээ

Залуучуудад хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх болон аж ахуй эрхлэх өөрөө өөртөө ажлын байр бий болгох, бүтээлч, шинэлэг санал, санаачилгыг дэмжих хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулна.

4.1. Ажил хайгч залуучуудад ажлын дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх

Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн болон гэр бүл, хүүхэд, залуучуудын байгууллага хамтран Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвөөр дамжуулан хөтөлбөрийн 2.1-2.4-т заасан иргэнийг ажлын дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээнд хамруулж, зохион байгуулна.

- 4.1.1. Залуучуудад ажлын дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээ үзүүлэхдээ ажил олгогчдыг бүртгэн гэрээ байгуулна. Гэрээ байгуулахдаа ажлын дадал, туршлага эзэмшүүлэх чиглүүлэгч ажилтан байгаа эсэх, үйлчилгээний үргэлжлэх хугацаа, дадал, туршлага эзэмшүүлсний дараа тухайн ажлын байранд ажил хайгч залууг ажиллуулах боломжтой эсэх, мөн хөдөлмөрийн гэрээ байгуулж, цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл тогтмол төлөх эсэхийг нь харгалзан үзнэ.
- 4.1.2. Их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагатай хамтран ажиллаж, ажлын дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээний талаар тэдгээрийн төгсөгчдөд мэдээлэл өгөх бөгөөд Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага болон хөдөлмөрийн биржид бүртгэлтэй байгаа ажил хайгч залуучуудын мэргэжил, мэргэшил, ажилласан жил, туршлагын талаар тусгайлан судалгаа хийж, зохих мэргэжил эзэмшсэн залуучуудад ажил олгогчийн хүсэлтийг танилцуулна.
- 4.1.3. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь ажлын дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх тухай хүсэлт гаргасан ажил олгогч болон сонирхсон ажил хайгч залуутай гурвалсан гэрээ⁵ байгуулна.
- 4.1.4. Гурвалсан гэрээ байгуулсан ажил олгогч нь дадал, туршлага эзэмшигчийн ажлын байрыг бэлтгэж, дадал, туршлага эзэмшигчтэй хөдөлмөрийн хугацаатай гэрээ байгуулна.
- 4.1.5. Ажлын дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээний хүрээнд холбогдох сургалтын болон сургалтын хэрэглэгдэхүүний зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэх бөгөөд зардлын хэмжээг үйлдвэрлэл дээрх сургалтын зардлын доод жишиг хэмжээгээр тооцно.
- 4.1.6. Ажлын дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээний үргэлжлэх хугацаа 45 хүртэл хуанлын хоног байна.

⁴ Гурвалсан гэрээний загварыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар батална.

4.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдыг ажил олгогчид дагалдуулан суралцуулах

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдыг суралцаж байх хугацаанд нь ажлын дадлага, ур чадвар эзэмшүүлж, сургуулиа төгсөөд хөдөлмөрийн зах зээлд шилжихэд нь дэмжих зорилгоор ажлын байранд дагалднаар сургана.

- 4.2.1. Ажил олгогч, дагалдан суралцах ажилтан, сургалтын байгууллага хамтран дагалдан суралцах хөдөлмөрийн гэрээ⁵ байгуулна.
- 4.2.2. Дагалдан суралцах ажилтны хөдөлмөрийн гэрээнд мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцах цаг, эзэмших мэргэжил, ажлын байран дээр ажиллах цаг, эзэмшвэл зохих ажлын дадлага, дадлагын хугацааны цалин хөлс, сургалтын хөтөлбөрийг талууд харилцан тохиролцож гэрээнд хавсаргана.
- 4.2.3. Цалин хөлстэй дадлагажих хугацаа нэг хичээлийн жилд 2 сараас ихгүй байна.
- 4.2.4. Дагалднаар суралцах ажилтанд олгох үндсэн цалинг талууд харилцан тохиролцох бөгөөд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доошгүй байна.
- 4.2.5. Дагалднаар суралцах ажилтанд Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар ажилтны нэмэгдэл, нэмэгдэл хөлс, олговрыг олгоно.
- 4.2.6. Дагалднаар суралцах ажилтны ажил олгогчоос болон ажилтнаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас төлөх бөгөөд холбогдох санхүүгийн баримтад үндэслэн улирал тутам нөхөн төлнө.



4.3. Шилдэг “Старт-Ап” залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох

Шинэ технологи, инновац бүхий шинэлэг санал, санаачлаг гаргаж, аж ахуй эрхлэх төсөл боловсруулсан шилдэг “Старт-Ап” залуу, залуучуудын багийг дараах байдлаар шалгаруулж, эргэн төлөх нөхцөлгүй санхүүгийн дэмжлэг олгоно.

- 4.3.1. Аймагт аймгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, Улаанбаатар хотод Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага шинэ технологи, инновац бүхий шинэлэг санал, санаачлаг гаргаж, аж ахуй эрхлэх төсөл боловсруулсан шилдэг “Старт-Ап” залуу, эсхүл залуучуудын багийг шалгаруулж, 10.0 сая төгрөгийн эргэн төлөх нөхцөлгүй санхүүгийн дэмжлэгийг олгоно;
- 4.3.2. Санхүүгийн дэмжлэгийг аймагт 1 шилдэг “Старт-Ап”-т, дүүрэгт 2 шилдэг “Старт-Ап”-т олгоно.
- 4.3.3. Шинэлэг санал, санаачлаг гаргаж, аж ахуй эрхлэх төсөл боловсруулах арга зүйн дэмжлэг, зөвлөгөөг амжилттай гарааны бизнес эрхлэгч, ментор, хөрөнгө оруулагч нараас сайн дурын үндсэн дээр авч болно;
- 4.3.4. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар улсын хэмжээний “Старт-Ап”-уудад 1 дүгээр байр (нэг баг) 20.0 сая, 2 дугаар байр (хоёр баг) 17.0 сая, 3 дугаар байр (гурван баг) 15.0 сая төгрөгийн эргэн төлөх нөхцөлгүй санхүүгийн дэмжлэгийг олгоно.
- 4.3.5. Улсын хэмжээнд оролцож шилдэг “Старт-Ап”-аар шалгарсан залуу, эсхүл залуучуудын баг нь хөтөлбөрийн 4.3.1-д заасан эргэн төлөх нөхцөлгүй санхүүгийн дэмжлэгт давхардан хамрагдахгүй.
- 4.3.6. Гарааны бизнес санааг баяжуулах, өрсөлдүүлэх, бүлгээр ажиллаж ирээдүйтэй санааг бизнесийн зөвлөх (ментор)-ийн туслалцаатайгаар хөгжүүлэх, шилдэг гарааны бизнесийг сонгон шалгаруулах, шалгарсан

“Старт-Ап”-ын үйл ажиллагааг дэмжих арга хэмжээг зохион байгуулах ажлыг мэргэжлийн эрх бүхий байгууллагатай гэрээний үндсэн дээр зохион байгуулна;

4.3.7. Мэргэжлийн байгууллага дараах дараалал бүхий арга зүй, агуулгаар сургалт, арга хэмжээг зохион байгуулна:

4.3.7.1. Бизнесийн санаа, бизнесийн санаагаа хөгжүүлэх оролцоонд тулгуурласан сургалт;

4.3.7.2. Загварчлах сэтгэлгээ (design thinking) буюу бизнес зөгварэлтийн боловсруулах сэтгэлгээний сургалт;

4.3.7.3. Бизнес модель хавтан (business model canvas) ашиглах сургалт;

4.3.7.4. Гарааны бизнесээ эхлүүлэх (Start-up weekend) – Гарааны бизнес санааг баяжуулах, өрсөлдүүлэх, багаар ажиллаж ирээдүйтэй санааг менторын туслалцаатайгаар хөгжүүлэх, гарааны бизнесийг сонгон шалгаруулах 54 цагийн үйл ажиллагаа;

4.3.7.5. Бэлтгэл хурдасгуур (Pre-accelerator) – Ментор 5 хоногийн турш хөгжүүлэх, бойжуулах;

4.3.7.6. Хөрөнгө оруулагчид, олон нийтэд төслөө танилцуулах өдөр (Demo day).



4.4. Оюутан, залуучуудыг цагийн ажилд зуучлах

Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн дагуу хувийн хэвшлийн байгууллагууд нийт ажилтнуудын 5 хувьтай тэнцэхүйц оюутны цагийн ажлын орон тоо гаргахад дэмжлэг үзүүлж, цагийн ажилд зуучлахдаа Засгийн газрын 2020 оны 228 дугаар тогтоолоор батлагдсан “Оюутны цагаар хөдөлмөр эрхлэх журам”-ын дагуу хэрэгжүүлнэ.

4.5. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төвд сургалт зохион байгуулах

4.5.1. Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь жилд 2-оос доошгүй удаа залуучуудад залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төвд дараах сургалт, зөвлөгөө үйлчилгээг мэргэжлийн талуудтай хамтран зохион байгуулна. Үүнд:

1. Гарааны бизнес эрхлэх зөвлөх үйлчилгээ,
2. Бизнес сэтгэлгээ буюу энтерпренершип,
3. Үйл ажиллагаа явуулж буй залуучуудын жижиг, дунд үйлчилгээнд арга зүй, зөвлөгөө мэдээллийн чиглэлээр дэмжлэг үзүүлэх.

Тав. Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн

Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар гаргахаас гадна хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага нь бүх шалгуур үзүүлэлтийг нас, хүйс, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр тус бүрээр нарийвчлан гаргаж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд сар бүр тайлагнана.

5.1. Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт

Түвшин	Үзүүлэлт	Баталгаажуулах эх сурвалж	Суурь түвшин (2021)	Хүрэх түвшин (2022)	Хүрэх түвшин (2023)
Гарцын шалгуур үзүүлэлт (output)	Залуучуудад ажлын дадлага, туршлага эзэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх арга хэмжээнд хамрагдсан хүн, аж ахуйн нэгжийн тоо тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ	ХХҮЕГ-ын сарын, жилийн тайлан	124 иргэн	2000 иргэн	2300 иргэн
	Дагалдан сургалтад хамрагдсан хүн, аж ахуйн нэгж, МСҮТ-ийн тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ		-	2000 иргэн	2300 иргэн
	Шилдэг “Старт-Ап” залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамрагдсан хүний тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ, арга хэмжээ тус бүрээр		39 иргэн	45 залуу болон залуучуудын баг	45 залуу болон залуучуудын баг
	Шилдэг “Старт-Ап”-аар шалгарсан бизнесийн төрөл, ангилалаар		-	-	-
	Цагийн ажилд бүртгүүлсэн, зуучлалын үйлчилгээнд хамрагдсан хүний		7497 иргэн	10,000 иргэн	11,000 иргэн



	тоо, хөрөнгийн хэмжээ				
	Нийт цагийн ажлын байрны захиалгын тоо, эдийн засгийн ангиллаар		-	-	
	Гарааны бизнес эрхлэх зөвлөх үйлчилгээнд хамрагдсан залуучуудын тоо		-	40 иргэн	100 иргэн
	Бизнес сэтгэлгээ буюу энтерпренершипын сургалтад хамрагдсан залуучуудын тоо		-	40 иргэн	100 иргэн
	Үйл ажиллагаа явуулж буй залуучуудын жижиг, дунд үйлдвэрлэлийн арга зүй, зөвлөгөө мэдээлэлд хамрагдсан залуучуудын тоо		-	40 иргэн	100 иргэн
Үр дүнгийн шалгуур үзүүлэлт (outcome)	Хөтөлбөрт хамрагдсанаар тогтмол ажлын байртай болсон, НДШ 6 сараас дээш хугацаагаар төлсөн, цагийн ажлын байрны тоо,	Мөшгөх судалгааны тайлан (хөтөлбөр хэрэгжиж дууссанаас хойш 1 жилийн дотор)		Хөтөлбөрт хамрагдах үеийн нөхцөл байдлын мэдээлэл	Суурь мэдээлэл дээр үндэслэн нэмэгдсэн ажлын байрны тоо



Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2022 оны 12 сарын 14-ны өдрийн
1 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралт



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Нэг. Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөр эрхлэх, хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн онцлог хэрэгцээнд нь нийцсэн тусгайлсан ажлын байр бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангахад ажил олгогчийг дэмжихэд хөтөлбөрийн зорилго нь оршино.

Хоёр. Хамрах хүрээ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт дараах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хамрагдана:

Иргэн:

- 2.1. Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын хүчин төгөлдөр шийдвэртэй, "Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүн;
- 2.2. Хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа хүн.

Аж ахуйн нэгж, байгууллага:

- 2.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангаж буй ажил олгогч;
- 2.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий, үйл ажиллагаагаа тогтвортой явуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангаж байгаа төрийн бус байгууллага.

Гурав. Хэрэгжүүлэх зарчим, удирдлага зохион байгуулалт

- 3.1. Хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага холбогдох арга хэмжээнд хамрагдахаар хандсан иргэнд хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээ (профайлинг) хийж, тэдгээрийн онцлог хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр хөтөлбөрт хамруулна.
- 3.2. Ажил, мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ, мэдээллийг хүргэх, ажил, мэргэжлээ сонгох болон хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах нөхцөлийн талаар зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах болон ажилд зуучлах үйлчилгээг иргэнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу үзүүлнэ.
- 3.3. Хөтөлбөрийг удирдлага, арга зүйгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, нэгдсэн зохицуулалтаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, зохион байгуулалтаар холбогдох байгууллагууд хангаж ажиллана.
- 3.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамж болон холбогдох үйл ажиллагааны зардлын жишиг хэмжээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд батална. Удирдамжид арга хэмжээний нарийвчилсан зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналт, хамрагдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тавигдах шалгуур үзүүлэлт, үр дүнг тодорхойлж, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага болон бусад шаардлагатай зохицуулалтыг тусгасан байна.
- 3.5. Хөтөлбөрийн холбогдох арга хэмжээний тайлангийн маягт болон арга хэмжээ тус бүрийг хэрэгжүүлэхэд шаардагдах гэрээнүүдийн жишиг загварыг Хөгжлийн

бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга батална. Тайлангийн маягтад хөтөлбөрт дурдсан арга хэмжээ тус бүрд хамрагдсан иргэний мэдээлэл, үр дүн, зарцуулсан хөрөнгийн хэмжээг нарийвчилсан байдлаар тусгах бөгөөд маягтыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын саналыг үндэслэж батална.

- 3.6. Энэ хөтөлбөрт тусгасан санхүүгийн дэмжлэгийг Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ын хүрээнд хэрэгжүүлж, зохион байгуулна.

Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөр эрхлэх, хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн онцлог хэрэгцээнд нь нийцсэн тусгайлсан ажлын байр бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангахад ажил олгогчийг дэмжих хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулна.

4.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн зах зээл дээр ажиллуулах дэмжлэгтэй хөдөлмөр эрхлэлтийн цогц арга хэмжээ.

Ажлын байрны дадлагажуулагчийн арга, аргачлалыг ашиглан хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн зах зээл дээр ажиллуулах дэмжлэгтэй хөдөлмөр эрхлэлтийн дараах цогц арга хэмжээг зохион байгуулна.

4.1.1. Ажилд тохиромжтой байдлын үнэлгээ:

- 4.1.1.1. Ажлын байрны дадлагажуулагч хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон ажлын байрны аль алиных нь хэрэгцээг үнэлэх;
- 4.1.1.2. Үнэлгээний суурь үйл ажиллагаа хийх;
- 4.1.1.3. Дадлагажуулагч сонгосон ажлын байран дээр очиж ажиллан мэдээлэл цуглуулах;
- 4.1.1.4. Ажил үүргийн шинжилгээ хийх;
- 4.1.1.5. Ажлын даалгаврын шинжилгээ хийх;
- 4.1.1.6. Ажлын байрны дадлагажуулагч нь дадлага-сургалтын үр дүнд үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажил үүрэг, орчны талаар ажил олгогчтой эцсийн хэлэлцээр, тохируулга хийх;
- 4.1.1.7. Ажлын байран дээрх дэмжлэгийн төлөвлөгөөг боловсруулах.

4.1.2. Ажлын байран дээрх дэмжлэг:

- 4.1.2.1. Сэтгэлзүйн дэмжлэг;
- 4.1.2.2. Сайн дурын болон төлөвлөгөөт дэмжлэг;
- 4.1.2.3. Ажлын байрны тохируулга хийх;
- 4.1.2.4. Бие даан ажиллах дэмжлэг үзүүлэх.

4.1.3. Гарах үйл явц, эргэх холбоо:

- 4.1.3.1. Гарах үйл явц нь тохиромжтой ажлын байр олох, ажлын байранд тохируулга хийх үеэс эхэлдэг;
- 4.1.3.2. Эргэх холбоог бий болгох;




4.1.3.3. Эрт илрүүлэг үнэлгээ хийх системийг бий болгох.

4.1.4. Ажлын байрны дадлагажуулагчийн тавигдах шаардлага, ажиллах аргачлал, цогц арга хэмжээний зөвшөөрөгдөх зардлын ангилал, түүний жишиг үнэ, дадлагажуулагчийн нэг цагийн ажлын хөлсний үнэлгээ зэргийг тусад нь удирдамж, журмаар зохицуулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батлан мөрдөж ажиллана.

4.1.5. Цогц арга хэмжээний зардлын хэмжээ нэг ажлын байранд 10.0 сая хүртэл төгрөг байх бөгөөд уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөтөч дохионы хэлний орчуулагч болон хувийн туслахын үйлчилгээг энэ зардалд багтаан хэрэгжүүлнэ.

4.1.6. Цогц арга хэмжээг журмаар зохицуулагдсан, тавигдах шаардлагыг хангасан аж ахуй нэгж, төрийн бус байгууллагууд хамрагдана.



4.2. Санхүүгийн дэмжлэг олгох

Ажлын байр шинээр бий болгох, хадгалахад чиглэсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төсөл, санал, санаачилгыг дэмжих зорилгоор дараах барьцаагүй, хүүгүй санхүүгийн дэмжлэгийг олгож, аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулна.

4.2.1. Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох:

4.2.1.1. Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ, өрхийн аж ахуй, хувиараа хөдөлмөр эрхэлж, ажлын байр бий болгох зорилготой хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа хүний боловсруулсан төслийг шалгаруулж, барьцаагүй, хүүгүй, 50 хувийг нь эргэн төлөх нөхцөлтэй, 5.0-10.0 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 36 хүртэл сарын хугацаатай олгоно. Хэрэв иргэн санхүүгийн дэмжлэгийг 5.0 сая төгрөгөөс бага хэмжээгээр авах бол хүсэлтээ бичгээр гаргана;

4.2.1.2. Сонгон шалгаруулалтаас 3-аас доошгүй долоо хоногийн өмнө тухайн нутаг дэвсгэрийн иргэд, олон нийтэд энэ тухай зар мэдээлэл, сурталчилгаа хийнэ;

4.2.1.3. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага жил бүрийн эхний болон гуравдугаар улиралд төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ба санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлт гаргасан иргэдийг бүртгэн төслүүдийг хүлээн авч сонгон шалгаруулна;

4.2.1.4. Төслийг аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын даргын тушаалаар байгуулсан ажлын хэсэг сонгон шалгаруулах ба сонгон шалгаруулалтын үе шат бүрийг ил тод, нээлттэй иргэд, оролцогчдын оролцоог хангасан байдлаар зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд төслийн санал ирүүлсэн иргэн өөрийн төслийг ажлын хэсэг болон ажлын хэсгийн үйл ажиллагааг хянаж байгаа иргэдийн төлөөлөлд танилцуулж болно;

4.2.1.5. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллийг заавал оруулна;

4.2.1.6. Санхүүгийн дэмжлэг авахаар шалгарсан иргэнтэй тухайн аймаг,

дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага гэрээ байгуулж, эргэн төлөлтийг хариуцан ажиллана.

4.2.2. Төрийн бус байгууллагад санхүүгийн дэмжлэг олгох:

4.2.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах чиглэлээр байнгын үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын боловсруулсан хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгэмшүүлэх зорилготой, төрийн бус байгууллагынхаа үндсэн үйл ажиллагааны чиглэлээр хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт нь нийцсэн тусгайлсан ажлын байр бий болгож, тогтвортой ажиллуулах тухай төслийг сонгон шалгаруулж, барьцаагүй, хүүгүй, 20.0 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 50 хувийн эргэн төлөх нөхцөлтэйгөөр 36 хүртэл сарын хугацаатайгаар олгоно;

4.2.2.2. Сонгон шалгаруулалтыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар зохион байгуулна;

4.2.2.3. Сонгон шалгаруулалтаас 3-аас доошгүй долоо хоногийн өмнө нийтэд мэдээлж, энэ тухай зар сурталчилгаа хийнэ;

4.2.2.4. Арга хэмжээг жил бүрийн эхний улиралд зохион байгуулах бөгөөд төслийн сонгон шалгаруулалтын дүн, шийдвэрийг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж, сонгон шалгаруулалттай холбоотой гарсан маргааныг хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ;

4.2.2.5. Сонгон шалгаруулалтыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын тушаалаар байгуулсан ажлын хэсэг сонгон шалгаруулах ба сонгон шалгаруулалтын үе шат бүрийг ил тод, нээлттэй иргэд, оролцогчдын оролцоог хангасан байдлаар зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд төслийн санал ирүүлсэн байгууллага өөрийн төслийг ажлын хэсэг болон ажлын хэсгийн үйл ажиллагааг хянаж байгаа иргэдийн төлөөлөлд танилцуулж болно;

4.2.2.6. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллийг заавал оруулна.


4.2.3. Аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг олгох:

4.2.3.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний үүсгэн байгуулсан аж ахуйн нэгжийн болон нийт ажиллагчдын 50-иас доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилладаг аж ахуйн нэгжийн бизнесээ өргөжүүлэх, шинээр тохируулгатай ажлын байр бий болгох тухай, мөн бусад аж ахуйн нэгжийн шинээр тохируулгатай ажлын байр бий болгож хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тогтвортой ажиллуулах тухай боловсруулсан төслийг шалгаруулж, барьцаагүй, хүүгүй, 30.0-50.0 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 100 хувь эргэн төлөх нөхцөлтэйгөөр 36-48 сарын хугацаатай олгоно;

4.2.3.2. Сонгон шалгаруулалтыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар зохион байгуулна;

4.2.3.3. Сонгон шалгаруулалтаас 3-аас доошгүй долоо хоногийн өмнө нийтэд мэдээлж, энэ тухай зар сурталчилгаа хийнэ;

4.2.3.4. Арга хэмжээг жил бүрийн эхний улиралд зохион байгуулах бөгөөд



төслийн сонгон шалгаруулалтын дүн, шийдвэрийг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж, сонгон шалгаруулалттай холбоотой гарсан маргааныг хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ;

- 4.2.3.5. Сонгон шалгаруулалтыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын тушаалаар байгуулсан ажлын хэсэг сонгон шалгаруулах ба сонгон шалгаруулалтын үе шат бүрийг ил тод, нээлттэй иргэд, оролцогчдын оролцоог хангасан байдлаар зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд төслийн санал ирүүлсэн аж ахуйн нэгж өөрийн төслийг ажлын хэсэг болон ажлын хэсгийн үйл ажиллагааг хянаж байгаа иргэдийн төлөөлөлд танилцуулж болно;
- 4.2.3.6. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллийг заавал оруулна.

4.2.4. Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах:

- 4.2.4.1. Энэ хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд шалгарч, хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шаардлагатай тохиолдолд аж ахуй эрхлэлтийн сургалтыг зохион байгуулж болно;
- 4.2.4.2. Аж ахуй эрхлэлтийн сургалтыг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулж хийхэд гарах нэмэлт зардлын жишиг хэмжээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд тогтооно;
- 4.2.4.3. Энэ хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд шалгарч, хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шаардлагатай тохиолдолд борлуулалтын дэмжлэгийг үзүүлнэ.

4.3. Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах

Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар бичил бизнес эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэн, нийт ажилчдын 50-иас доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байдаг аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын хүсэлтэд үндэслэн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулахад дэмжлэг үзүүлэх болон ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлнэ.

- 4.3.1. Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтөд үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ажлын байр түрээслэн 6 сараас дээш хугацаагаар тасралтгүй үйл ажиллагаа эрхэлсэн хувиараа хөдөлмөр эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэн, мөн нийт ажилчдын 50-иас доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байдаг аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, бизнес инкубатор төвийн бойжигчид тухайн жилийн 6 хүртэл сарын хугацаанд түрээсийн төлбөрийн дэмжлэгийг олгоно.
- 4.3.2. Холбогдох баримт бичиг, түрээсийн гэрээг үндэслэн нөхцөл байдлыг газар дээр нь үнэлгээ хийж, тодорхойлсны үндсэн дээр ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг улиралд нэг удаа нөхөн олгоно. Түрээсийн төлбөрийг нөхөн олгохдоо тухайн төлбөрийг төлсөн баримтыг үндэслэнэ.
- 4.3.3. Ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг авсан иргэн, аж ахуйн нэгж, Төрийн бус байгууллага тухайн иргэдийн ажлын байрыг хадгалах үүрэг хүлээх бөгөөд энэ тухайг холбогдох гэрээнд тусгаж, зохион байгуулагч талтай байгуулна.
- 4.3.4. Хөгжлийн бэрхшээлтэй бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бараа,

бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулахад дэмжлэг үзүүлэх үзэсгэлэн, яармагийг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар зохион байгуулна. Мөн гадаадад зохион байгуулагдаж байгаа үзэсгэлэн худалдаанд оролцоход нь дэмжлэг үзүүлнэ.

- 4.3.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бараа, хөдөлмөрийн хуулийн 144.3 дахь заалтыг хэрэгжүүлэх борлуулах ажлыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага зохион байгуулж ажиллана.

4.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх



Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дараах урамшуулал, дэмжлэгийг олгоно.

- 4.4.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан ажил олгогчид байнгын ажлын байраар хангасан хөгжлийн бэрхшээлтэй ажилтны тоогоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг нэг удаа олгоно.
- 4.4.2. 25 болон түүнээс дээш тооны ажилтантай ажил олгогч Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тогтоосон хувиас давсан хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан бол хуулиар тогтоосон хувиас давсан байнгын ажлын байраар хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүний тоогоор урамшууллыг тус бүр нэг удаа олгоно.
- 4.4.3. Энэ журмын 4.4.1-т заасан урамшууллыг хөгжлийн бэрхшээлтэй хүнийг байнгын ажлын байраар хангаж 12 сараас доошгүй хугацаагаар цалин олгож, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дотоодын төрийн бус байгууллагад нэг удаа олгоно.

4.5. Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг богино хугацаанд мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг танхимийн болон үйлдвэрлэл дээрх хэлбэрээр дараах байдлаар зохион байгуулна.

- 4.5.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг мэргэжлийн ур чадвар, чадамжийг 1-10 сарын хугацаанд багтаан эрх бүхий мэргэшсэн боломжит тохируулгатай сургалтын орчин бүрдсэн мэргэжлийн байгууллага, иргэнтэй гэрээлэн гүйцэтгүүлэх бөгөөд уг сургалт нь модуль хэлбэртэй тусгайлсан сургалтын хөтөлбөрт суурилсан байна.
- 4.5.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг мэргэжлийн чадамж эзэмшүүлэх, үйлдвэрлэл дээрх ажлын байрны зэрэг тухайн хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирсон төрөл хэлбэрийг сонгон зохион байгуулна. Энэ арга хэмжээний хүрээнд хөтөч дохионы хэлмэрчийг бэлтгэх хараагүй хүмүүсийн орон зайн чиг баримжаа олгох сургалт болон хөгжлийн бэрхшээлийн бусад төрөл хэлбэрийн онцлогт тохирсон нэмэлт сургалтыг хийж болно.

4.5.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт нийцүүлэн мэргэжлийн ур чадварын тусгайлсан сургалтыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэргэжлийн сургалт зохион байгуулах дадлага, туршлага бүхий сургалтын байгууллагаар гэрээний үндсэн дээр зохион байгуулна.

4.5.4. Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд “Мэргэжлийн сургалтаар чадамж, мэргэжил эзэмшсэн төгсөгч, иргэдийн мэргэшлийн түвшнийг үнэлэх, баталгаажуулах журам”-ын дагуу ур чадварын шалгалтыг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын оролцоог ханган зохион байгуулж, Чадамжийн гэрчилгээ олгох ба иргэн өөрөө хүсвэл мэргэжлийн зэрэг олгох шалгалтад хамрагдаж болно.

4.5.5. Мэргэжлийн сургалт зохион байгуулах байгууллагын сургалтын хөтөлбөр, сургалт зохион байгуулах танхим хэрэглэгдэхүүнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар хянаж хөдөлмөр эрхлэлтийн сургалтын мэргэшсэн байгууллагуудын жагсаалтыг гаргана.

4.6. Бусад үйл ажиллагаа

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбоотой бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран ажиллана.

4.6.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн байдал, Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтэд зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэх;

4.6.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлттэй холбоотой судалгаа хийж, эрх зүйн орчин, дүрэм журмыг сайжруулах тухай санал боловсруулах;

4.6.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн сайн жишээг түгээн дэлгэрүүлэх сурталчилгаа, нөлөөллийн ажил хийх;

4.6.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой мэдээллийн санг боловсронгуй болгох;

4.6.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 18.1.3 дахь заалтын дагуу мэргэжлээрээ ажиллахад шаардагдах ажлын багаж, тоног төхөөрөмж, материал болон бусад шаардлагатай хэрэгслийг худалдан авахад нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нэг удаа санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

4.6.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт нийцсэн тусгайлсан ажлын байрыг шинээр бий болгож турших;

4.6.7. Хөдөлмөр эрхлэх боломжтой хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хувийн туслахын үйлчилгээ үзүүлэх арга хэмжээ, хувийн туслах бэлтгэх сургалт зохион байгуулах;

4.6.8. Хөдөлмөрийн нөхөн сэргээх үйлчилгээг шинээр нэвтрүүлэхтэй холбоотой судалгаа хийх, журам, дүрэм боловсруулж, турших нэвтрүүлэх;

4.6.9. Бусад хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэхтэй холбоотой үйл ажиллагаа.

Тав. Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн

Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар гаргахаас гадна хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага нь бүх шалгуур үзүүлэлтийг нас, хүйс, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр тус бүрээр нарийвчлан гаргаж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд сар бүр тайлагнана.

5.1. Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт

Түвшин	Үзүүлэлт	Баталгаажуулах эх сурвалж	Суурь түвшин (2021)	Хүрэх түвшин (2022)	Хүрэх түвшин (2023)
Гарцын шалгуур үзүүлэлт (output)	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрийн зах зээл дээр ажиллуулах дэмжлэгтэй хөдөлмөр эрхлэлтийн цогц арга хэмжээнд хамрагдсан хүний тоо арга хэмжээ тус бүрээр, зарцуулсан хөрөнгийн хэмжээ	ХБХХЕГ-ын сарын, жилийн тайлан	271 иргэн	70 иргэн	80 иргэн
	Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамрагдсан хүн, аж ахуйн нэгж, байгууллагын тоо, зарцуулсан хөрөнгө, эргэн төлөлтийн хэмжээ арга хэмжээ тус бүрээр		696 иргэн	625 иргэн	650 иргэн
	Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид үзүүлэх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагын тоо, зарцуулсан хөрөнгө, эргэн төлөлтийн хэмжээ арга хэмжээ тус бүрээр		65	75	80
	Аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдсан хүн, аж ахуйн нэгжийн тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ		1334 иргэн	1800 иргэн	1900 иргэн
	Борлуулалтын дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамрагдсан				



	хүн, аж ахуйн нэгж, байгууллагын тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ		35 иргэн		
	Ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамрагдсан хүн, аж ахуйн нэгж, байгууллагын тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ		-	300 иргэн	320 иргэн
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хамрагдсан хүн, ажил олгогчийн тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ		49 ажил олгогч	100 ажил олгогч	100 ажил олгогч
	Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдсан хүний тоо, сургалтын төрөл, мэргэжлээр		555 иргэн	400 иргэн	420 иргэн
	Бусад үйл ажиллагааны тайлан, арга хэмжээ тус бүрээр				
Үр дүнгийн шалгуур үзүүлэлт (outcome)	Хөтөлбөрт хамрагдсанаар тогтмол ажлын байртай болсон, НДШ 6 сараас дээш хугацаагаар төлсөн хүний тоо	Мөшгөх судалгааны тайлан (хөтөлбөр хэрэгжиж дууссанаас хойш 1 жилийн дотор)		Хөтөлбөрт хамрагдах үеийн нөхцөл байдлын мэдээлэл	Суурь мэдээлэл дээр үндэслэн нэмэгдсэн ажлын байрны тоо



Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2022 оны 02 сарын 11-ны өдрийн
1 дүгээр тогтоолын төвдугаар хавсралт



АХМАДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Нэг. Зорилго

Ахмад мэргэжилтнүүдийн ажил, хөдөлмөрт оролцох оролцоог нэмэгдүүлж, мэдээллийн сан үүсгэн, тэдний мэдлэг, ажлын туршлагыг өсвөр хойч, залуу үеийнхэнд өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх болон хувиараа аж ахуй эрхэлж орлогоо нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Хоёр. Хөтөлбөрийн хамрах хүрээ

Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт дараах иргэн аж ахуйн нэгж, байгууллага хамрагдана:

Иргэн:

- 2.1. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст хүсэлт гарган мэдээллийн санд бүртгүүлсэн тэтгэврийн насны ахмад мэргэжилтнүүд; (Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөл, ажил мэргэжлийн нөхцөл, цэргийн алба хаагчийн тэтгэвэрт гарсан);
- 2.2. Аж ахуй, өрхийн үйлдвэрлэл эрхлэх зорилготой ахмад настан.

Аж ахуйн нэгж, байгууллага:

- 2.3. Ахмад настны эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, холбоод.

Гурав. Хэрэгжүүлэх зарчим, удирдлага зохион байгуулалт

- 3.1. Хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага холбогдох арга хэмжээнд хамрагдахаар хандсан иргэнд хөдөлмөр эрхлэх үр чадварын үнэлгээ (профайлинг) хийж, тэдгээрийн онцлог хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр хөтөлбөрт хамруулна.
- 3.2. Ажил, мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ, мэдээллийг хүргэх, ажил, мэргэжлээ сонгох болон хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах нөхцөлийн талаар зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах болон ажилд зуучлах үйлчилгээг иргэнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу үзүүлнэ.
- 3.3. Хөтөлбөрийг удирдлага арга зүйгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, нэгдсэн зохицуулалтаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, зохион байгуулалтаар хөтөлбөрт нэр дурдсан харьяа байгууллагууд хангаж ажиллана.
- 3.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгдсэн удирдамж болон холбогдох үйл ажиллагааны зардлын жишиг хэмжээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд батална. Удирдамжид арга хэмжээний нарийвчилсан зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналт, хамрагдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тавигдах шалгуур, үзүүлэлтийг тодорхойлж, арга хэмжээний үйл явц, үе шат, үр дүн, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага болон бусад шаардлагатай зохицуулалтуудыг тусгасан байна.
- 3.5. Хөтөлбөрийн холбогдох арга хэмжээний тайлангийн маягт болон арга хэмжээ тус бүрийг хэрэгжүүлэхэд шаардагдах гэрээнүүдийн жишиг загварыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга батална. Тайлангийн маягтад хөтөлбөрт дурдсан арга хэмжээ тус бүрт хамрагдсан иргэний мэдээлэл, үр дүн,

зарцуулсан хөрөнгийн хэмжээг нарийвчилсан байдлаар тусгах бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны саналыг үндэслэн батална.

- 3.6. Энэ хөтөлбөрт тусгасан эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийг Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ын хүрээнд хэрэгжүүлж, зохион байгуулна.

Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээ

Ахмад мэргэжилтнүүдийн ажил, хөдөлмөрт оролцох оролцоог нэмэгдүүлж, мэдээллийн сан үүсгэн, тэдний мэдлэг, ажлын туршлагыг өсвөр хойч, залуу үеийнхэнд өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх болон хувиараа аж ахуй эрхэлж орлогоо нэмэгдүүлэх хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулна.

4.1. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг зохион байгуулах⁶

Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь хөтөлбөрийн 2.1-т заасан ахмад настныг дараах арга хэмжээнд хамруулна.

- 4.1.1. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төслийн тавигдах шаардлагыг холбогдох мэдээллийн хамт нийтэд ил тод зарлан мэдээлж, зохион байгуулах ба аймаг, нийслэл, дүүргүүд тус бүрд төслийг сонгон шалгаруулна. Ахмад мэргэжилтний зөвлөн туслах үйл ажиллагаа шаардлагатай байгууллагууд /эрэлт хэрэгцээгээ ирүүлэхийг хүссэн урилга, мэдээлэл хүргүүлсэн байх/ зөвлөх үйлчилгээ авах хэрэгцээ, шаардлага, ажлын цар хүрээг тодорхойлсон төслийг аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ирүүлнэ.
- 4.1.2. Төсөлд хамрагдан ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ үзүүлж буй ахмадад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан зардлын жишиг хэмжээгээр ажилласан цагийн урамшууллыг тооцож, төсөлд хамрагдсан байгууллагын ирүүлсэн тайлан, ажлын цагийн бүртгэлд үндэслэн урамшууллыг ахмад мэргэжилтэнд олгоно.
- 4.1.3. Зөвлөх мэргэжилтний төслийн хүрээнд олгох урамшууллыг тооцохдоо нэг жил хүртэлх хугацаанд ажлын 30 өдөр буюу нийт 240 цагаас хэтрэхгүй байхыг төсөл, холбогдох гэрээнд тусган ажиллана.
- 4.1.4. Тухайн төсөлд хамрагдаж буй ахмад мэргэжилтэн өөрийн эзэмшсэн ур чадвар, туршлагад үндэслэн зөвлөх үйлчилгээ үзүүлнэ.
- 4.1.5. Төсөл хэрэгжүүлэгч ахмад мэргэжилтэнд аймаг, сум орон нутгийн захиргаа, бусад байгууллагаас үйл ажиллагаа явуулах байр, техник хэрэгсэл, ажиллах нөхцөл, шаардагдах материал түүхий эд, санхүүгийн болон дэмжлэг үзүүлэх ба гүйцэтгэж буй ажил, үүрэгтэй нь уялдуулан нэмэлт цалин хөлсийг зохих хууль тогтоомжийн дагуу олгож болно.

4.2. Ахмадын төрийн бус байгууллагуудаар зөвлөх үйлчилгээг зохион байгуулах

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар бүтээн байгуулалт болон бусад салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудад ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ үзүүлэх хөтөлбөрийн 2.3-т заасан ахмадын эрх ашгийг хамгаалсан холбоодтой хамтран ажиллах гэрээний үндсэн дээр зохион байгуулна.

⁶Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь "Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд хамрагдах зөвлөхүүдийн мэдээллийн нэгдсэн сан"-г үүсгэж, хяналт тавьж ажиллана.

4.2.1. Зөвлөх үйлчилгээний төслийг хэрэгжүүлэх ахмад настны эрх ашгийг хамгаалах холбоо тухайн зөвлөх үйлчилгээний чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмж үзүүлэх мэргэжлийн өндөр ур чадвартай баг, бүрэлдэхүүнтэй байна.

4.2.2. Ахмад мэргэжилтний багийн зөвлөх үйлчилгээний төсөл хэрэгжүүлэх ахмадын төрийн бус байгууллага нь төсөлд хамрагдах хүний тоо, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллах төр, хувийн хэвшлийн байгууллагын хүсэлт, ажиллах байршил, гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төслийн холбогдох баримт бичгийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт ирүүлнэ.

4.2.3. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь зөвлөх үйлчилгээний захиалгад үндэслэн ирүүлсэн төслийг сонгон шалгаруулж, төсөлд хамрагдах ахмад мэргэшсэн зөвлөх мэргэжилтнүүдийг "Ахмад мэргэшсэн зөвлөхүүдийн нэгдсэн мэдээллийн сан"-д бүртгэнэ. Төслийн зориулалтаар хуваарилагдсан хөрөнгө, түүний зарцуулалт олон нийтэд ил тод, нээлттэй байна.

4.2.4. Төслийн үйл ажиллагаа эхлэхэд санхүүжилтийн 70 хувийг, төслийн явц, ур дүнг үндэслэн үлдэгдэл 30 хувийг санхүүжүүлнэ.

4.2.5. Төслийн үйл ажиллагаанд ахмадын баг, бүлгийг ажиллуулах ажил олгогч, төрийн захиргаа үйлчилгээний байгууллага нь ажиллах нөхцөл, байр, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах болон ажлын нэмэгдэл хөлс, цалинг олгож болно.

4.2.6. Энэ арга хэмжээнд хамрагдаж буй ахмад мэргэжилтнүүд нь аймаг, орон нутагт хэрэгжүүлэх ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төсөлд давхардан хамрагдахгүй.

4.3. Аж ахуй болон өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд нь зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгох

Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага аж ахуй, өрхийн үйлдвэрлэл эрхлэх зорилготой хөтөлбөрийн 2.2-т заасан ахмад настанд дараах санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамруулна.

4.3.1. Ахмад настны төслийн тавигдах шаардлагыг холбогдох мэдээллийн хамт нийтэд ил тод зарлан мэдээлж, 2 дугаар улиралд багтаан зохион байгуулах ба аймаг, нийслэл, дүүргүүд тус бүрд төслийг сонгон шалгаруулна.


4.3.2. Ахмад нь аж ахуй болон өрхийн үйлдвэрлэл эрхлэх зорилгоор боловсруулсан төслөө харьяа аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ирүүлэх ба төсөлд олгох эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн хэмжээ 5.0 хүртэл сая төгрөг байна.

4.3.3. Санхүүгийн дэмжлэг нь 24 сарын дотор 100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй байх бөгөөд эргэн төлөлтийн хуваарийг иргэний саналыг үндэслэн тогтоож, холбогдох гэрээнд тусгана.

4.3.4. Санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагааны сонгон шалгаруулалтыг "Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн 4.1.1-т заасан санхүүгийн дэмжлэгийг олгох үйл ажиллагаатай нийцүүлэн зохион байгуулна.

4.4. Хүүхэд хамгаалагч үйлчилгээг зохион байгуулах

4.4.1. Аймаг, дүүргийн Цагдаагийн газар, хэлтэс, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэс боловсролын байгууллага, хүүхдийн байгууллага,



цэрэг, цагдаагийн байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан 65 хүртэлх насны ахмад настныг хүүхэд хамгаалагчаар сонгон авч, сургалтад хамруулах ба хүүхэд хамгаалагч нартай хамтран ажиллах сайн дурын ажилтнуудыг мэдээллээр ханган ажиллана.


- 4.4.2. Цагдаагийн газар, хэлтэс нийслэлд хорооны, аймгийн төвд сум, багийн Засаг даргатай хамтран Хүүхэд хамгаалагчийн хариуцан ажиллах хэсгийг тодорхойлж батална.
- 4.4.3. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэс, Цагдаагийн газар, хэлтэс хүүхэд хамгаалагч нарт сургалт зохион байгуулж, мэдээллээр хангаж, гэрээ байгуулан хамтарч ажиллана.
- 4.4.4. Аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэс, Цагдаагийн газар, хэлтэс нь Хүүхэд хамгаалагч нарын цагийн тооцоо, ажлын тайланг сар бүрийн сүүлийн 7 хоногт нэгтгэн аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад гаргаж өгнө. Хүүхэд хамгаалагч бүр өдөрт 4-өөс дээшгүй, сард 80-аас дээшгүй цаг ажиллана.
- 4.4.5. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь 4.4.4-т заасан ажлын тайлан, цагийн тооцоог үндэслэн гэрээ байгуулсан Хүүхэд хамгаалагч /ахмад настан/-д урамшууллыг олгоно. Ажлын урамшууллын жишиг хэмжээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд тогтооно.
- 4.4.6. Хүүхэд хамгаалагч үйлчилгээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн "Хүүхэд хамгаалагч" төслийг хэрэгжүүлэх тухай А/55 дугаар тушаалд нийцүүлэн хэрэгжүүлнэ.



Тав. Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн

5.1. Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр тооцно. Үүнд:

Түвшин	Үзүүлэлт	Баталгаажуулах эх сурвалж	Суурь түвшин (2021)	Хүрэх түвшин (2022)	Хүрэх түвшин (2023)
Гарцын шалгуур үзүүлэлт (output)	Зөвлөх үйлчилгээнд хамрагдсан ахмад мэргэжилтний тоо, нас, хүйс, салбар, мэргэжлээр;	ХХҮЕГ-ын сарын, жилийн тайлан	560 иргэн	870 иргэн	900 иргэн
	Зөвлөх үйлчилгээнд хамрагдсан ахмад настны төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын тоо, салбар, мэргэжлээр;		-		
	Хүүхэд хамгаалагч үйлчилгээнд хамрагдсан хүний тоо.		187 иргэн	272 иргэн	300 иргэн
	Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан хүний тоо;		381 иргэн	900 иргэн	1000 иргэн
Үр дүнгийн шалгуур үзүүлэлт (outcome)	Хөтөлбөрт хамрагдсанаар түр болон тогтмол ажлын байртай бий болсон хүний тоо	Мөшгөх судалгааны тайлан (хөтөлбөр хэрэгжиж дууссанаас хойш 1 жилийн дотор)		Хөтөлбөрт хамрагдах үеийн нөхцөл байдлын мэдээлэл	Суурь мэдээлэл дээр үндэслэн нэмэгдсэн ажлын байрны тоо



Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2022 оны 7 сарын 7-ны өдрийн
1 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралт



“НОГООН АЖЛЫН БАЙР” ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн зорилго

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 14 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд ногоон хөгжлийн болон нийтийн төлөөх ажилд ажилгүй иргэдийн оролцох боломжийг хангах, иргэдийг эх орныхоо байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, өөрсдийн амьдарч буй орчны нийтийн эзэмшлийн зам, талбайг сайжруулахад дэмжлэг үзүүлэх замаар ажлын байраар хангаж, орлогыг нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Хоёр. Хамрах хүрээ

Ногоон ажлын байр хөтөлбөрт дараах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хамрагдана:

Иргэн:

- 2.1. Ажилгүй иргэн;
- 2.2. Ажил олоход хүндрэлтэй иргэн.

Аж ахуйн нэгж, байгууллага:

- 2.3. Нутгийн захиргааны байгууллага;
- 2.4. Мэргэжлийн холбоо болон төрийн бус байгууллага.

Гурав. Хэрэгжүүлэх зарчим, удирдлага зохион байгуулалт

- 3.1. Хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага холбогдох арга хэмжээнд хамрагдахаар хандсан иргэнд болон хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдаж байгаа өрхийн хөдөлмөрийн насны бөгөөд хөдөлмөрийн чадвартай иргэнд хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээ (профайлинг) хийж, тэдгээрийн онцлог хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр хөтөлбөрт хамруулна.
- 3.2. Ажил, мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ, мэдээллийг хүргэх, ажил, мэргэжлээ сонгох болон хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах нөхцөлийн талаар зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах болон ажилд зуучлах үйлчилгээг иргэнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу үзүүлнэ.
- 3.3. Хөтөлбөрийг удирдлага арга зүйгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, нэгдсэн зохицуулалтаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, зохион байгуулалтаар хөтөлбөрт нэр дурдсан харьяа байгууллагууд хангаж ажиллана.
- 3.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгдсэн удирдамж болон холбогдох үйл ажиллагааны зардлын жишиг хэмжээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд батална. Удирдамжид арга хэмжээний нарийвчилсан зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналт, хамрагдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тавигдах шалгуур, үзүүлэлтийг тодорхойлж, арга хэмжээний үйл явц, үе шат, үр дүн, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага болон бусад шаардлагатай зохицуулалтуудыг тусгасан байна.
- 3.5. Хөтөлбөрийн холбогдох арга хэмжээний тайлангийн маягт болон арга хэмжээ тус бүрийг хэрэгжүүлэхэд шаардагдах гэрээнүүдийн жишиг загварыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга батална. Тайлангийн маягтад

хөтөлбөрт дурдсан арга хэмжээ тус бүрт хамрагдсан иргэний мэдээлэл, үр дүн, зарцуулсан хөрөнгийн хэмжээг нарийвчилсан байдлаар тусгах бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны саналыг үндэслэн батална.

Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээ

Ногоон хөгжлийн болон нийтийн төлөөх ажилд ажилгүй иргэдийн оролцох боломжийг хангах, иргэдийг эх орныхоо байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, өөрсдийн амьдарч буй орчны нийтийн эзэмшлийн зам, талбайг сайжруулахад дэмжлэг үзүүлэх замаар ажлын байраар хангаж, орлогыг нэмэгдүүлэх хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулна.



4.1. Мод тарих арга хэмжээ

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангахад болон байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг дэмжих, иргэдийн идэвх санаачилгыг нэмэгдүүлэхэд ажилгүй иргэдийн оролцоог хангаж, тэдний орлогыг нэмэгдүүлэх зорилгоор мод тарих, суулгах арга хэмжээг зохион байгуулна.

- 4.1.1. Сум, хорооны бүртгэлтэй ажилгүй иргэдээс 2 болон түүнээс дээш хүний бүрэлдэхүүнтэй багуудыг зохион байгуулж, мод тарих арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 4.1.2. Багийн ахлагчийг багийн гишүүдийн саналаар томилох бөгөөд тухайн баг нийгмийн дэмжлэг тусламж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүнийг түлхүү хамруулахад анхаарч ажиллана.
- 4.1.3. Мод тарих, ногоон ажлын байрыг бий болгох, мод нийлүүлэх ажлыг мод үржүүлгийн мэргэжлийн байгууллага, иргэдийн бүлгийн гишүүдийг сургах болон модны санхүүжилтийг төсвийн эрх бүхий Засаг дарга хариуцан ажиллах бөгөөд мод тарих, ажлын урамшууллыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.
- 4.1.4. Ногоон ажлын байр бий болгох, мод тарих, түр ажлын байр бий болгох талаар аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын дарга тухайн орон нутгийн Засаг даргатай гэрээ байгуулан ажиллана.
- 4.1.5. Орон нутгийн анхан шатны нэгжид ажиллаж буй хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан, баг, хорооны Засаг дарга, Хэсгийн ахлагч нар хамтран иргэдийн санал хүсэлтэд үндэслэн тус арга хэмжээнд хамрагдах ажилгүй, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүнийг мод тарих арга хэмжээнд хамруулахаар нэрсийг гарган, бүлэг бүрдүүлнэ.
- 4.1.6. Тухайн бүлэг нь баг, хорооны нутаг дэвсгэрт болон бусад шаардлагатай байршилд мод тарих ажил хийж гүйцэтгэнэ.
- 4.1.7. Арга хэмжээнд хамрагдах иргэдэд мод тарих арга аргачлал, ач холбогдлын талаар мэдлэг олгох сургалтыг “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд бэлтгэгдсэн эрх бүхий сургагч багшаас танхимын болон талбайн сургалтыг зохион байгуулах бөгөөд энэ арга хэмжээний зардлыг орон нутгийн Засаг дарга хариуцна.
- 4.1.8. Сургалтад хамрагдсан бүлэг нь тухайн шатны Засаг даргаас баталсан төлөвлөгөө, зураглалын дагуу мод тарих ажлыг мэргэжлийн байгууллагын

удирдлага дор тарих бөгөөд тарьсан модны тоо⁷ ажилласан өдөр, цагаар тооцон бүлгийн гишүүн бүрд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан нийтийг хамарсан ажлын зардлын жишгээр ажлын хөлсийг тооцож олгоно.

- 4.1.9. Иргэдийн бүлгийн тарьсан мод, ажилласан өдөр, ажлын үр дүнд аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын ажилтан хяналт тавьж бүртгэл хөтлөх бөгөөд ажлын мэдээ, тайланг батлагдсан маягтын дагуу гаргана.

4.2. Нийтийг хамарсан ажил зохион байгуулах

Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй бусад нөхцөл байдлын улмаас үүссэн хор уршгийг арилгах, нөхөн сэргээх, нийтийн эзэмшлийн гудамж зам, талбайд бүтээн байгуулалт хийх, сайжруулах, тохижилт хийх, хог хаягдалгүй байлгах, байгаль орчныг хамгаалах, ой цэвэрлэх, голын ай сав, үер усны даланг цэвэрлэх, усны нөөц сан байгуулах, засварлах зэрэг үйл ажиллагааг нийтийг хамарсан ажлын хүрээнд зохион байгуулах бөгөөд ажилгүй болон ажилд ороход хүндрэлтэй иргэнийг хамруулна.

- 4.2.1. Орон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага орон нутгийн ажилгүй иргэдийг түр ажлын байраар хангах төсөл, төлөвлөгөөг боловсруулж, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ирүүлнэ.
- 4.2.2. Нийтийг хамарсан ажил зохион байгуулах төсөл, төлөвлөгөөний жишиг загвар болон төслийн үнэлгээний аргачлалыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга батална.
- 4.2.3. Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага төслийг хүлээн авч, бий болгох түр ажлын байрны тоо, гүйцэтгэх ажлын зардал, санхүүгийн тооцоо зэргийг хянан үзээд дэмжигдсэн төсөл, төлөвлөгөөг хэрэгжүүлэх нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах шийдвэр гаргаж, гэрээ байгуулна.
- 4.2.4. Нийтийг хамарсан ажилд хамрагдах иргэдийг сард ажлын 10 хүртэл хоногоор, өдөрт 8 хүртэл цагаар ажиллуулах ба ажилласан иргэдийн цалин хөлс, хөдөлмөрийн аюулгүй байдал болон эрүүл ахуйн зардлыг ажилласан цагаар тооцож өдрөөр болон ажил хийгдэж дууссаны дараа олгоно.⁸
- 4.2.5. Нийтийг хамарсан ажилд хамрагдсан иргэдийн ажлын хөлс, зардлыг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага тухайн иргэний банкна дахь нэрийн дансанд шилжүүлнэ.
- 4.2.6. Нийтийг хамарсан ажлыг гэрээлэн гүйцэтгэх нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж нь хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн үүрэгт ажлыг нийтийг хамарсан ажлаар гүйцэтгүүлэхийг хориглоно.
- 4.2.7. Нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээнд хамрагдсан иргэдэд олгосон цалин хөлснөөс Нийгмийн даатгалын шимтгэлийг тооцохгүй бөгөөд иргэн сайн дурын даатгалд хамрагдаж болно.

⁷ Ажлын цагт ногдох тарих модны тоог мэргэжлийн байгууллагын жишгээр тогтооно.

⁸ Төсөл боловсруулсан байгууллага нь хөдөлмөрийн аюулгүй байдал болон эрүүл ахуйн зардлыг урьдчилан гарах бөгөөд ажилласан иргэдийн жишиг зардлын дагуу нөхөн авна.

4.2.8. Нийтийг хамарсан ажилд хуваарилсан хөрөнгийн 10.0-15.0 хувийг хог, хаягдал цэвэрлэх үйл ажиллагааны зардалд зарцуулна.

Тав. Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн

Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар гаргахаас гадна хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага нь бүх шалгуур үзүүлэлтийг нас, хүйс, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр тус бүрээр нарийвчлан гаргаж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд сар бүр тайлагнана.



5.1. Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт

Түвшин	Үзүүлэлт	Баталгаажуулах эх сурвалж	Суурь түвшин (2021)	Хүрэх түвшин (2022)	Хүрэх түвшин (2023)
Гарцын шалгуур үзүүлэлт (output)	Мод тарих арга хэмжээнд хамрагдсан хүний тоо, зарцуулсан хөрөнгө;	ХХҮЕГ-ын сарын, жилийн тайлан	-	11000 иргэн	
	Тарьсан модны тоо;			200,000	
	Нийтийг хамарсан ажилд хамрагдсан хүний тоо, зарцуулсан хөрөнгө			11000 иргэн	
	Нийтийг хамарсан ажилд хамрагдсан байгууллагуудын жагсаалт, төслийн чиглэл тус бүрээр				
Үр дүнгийн шалгуур үзүүлэлт (outcome)	Мод тарих ур чадвар эзэмшин цаашид энэ чиглэлээр ажиллаж буй иргэдийн тоо; Ажилд зуучлагдан байнгын ажлын байртай болсон хүний тоо	Мөшгөх судалгааны тайлан (хөтөлбөр хэрэгжиж дууссанаас хойш 1 жилийн дотор)		Хөтөлбөр т хамрагдах үеийн нөхцөл байдлын мэдээлэл	Суурь мэдээлэл дээр үндэслэн нэмэгдсэн ажлын байрны тоо

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2022 оны 4 сарын 7-ны өдрийн
1 дүгээр тогтоолын долоодугаар хавсралт



ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн зорилго, зорилт

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн зах зээлд эргэн нэвтрэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор ажиллах хүчнээс гадуур байгаа эмэгтэйчүүдийг хөдөлмөр эрхлэхэд тулгарч буй бэрхшээлийг арилгаж, тэдэнд болон гэртээ удаан хугацаагаар хүүхдээ харж буй бага насны хүүхэдтэй ээжүүдэд цахим болон шаардлагатай ур чадвар олгох, сургалт, дэмжлэгт хамруулах замаар тэдний орлогыг нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Хоёр. Хамрах хүрээ

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт дараах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хамрагдана:

Иргэн:

- 2.1. Ажилгүй эмэгтэйчүүд;
- 2.2. Гэртээ бага насны хүүхдээ асран хүмүүжүүлж буй эмэгтэйчүүд;
- 2.3. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд;
- 2.4. Хувиараа хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүд;
- 2.5. Жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эмэгтэй;
- 2.6. Өрхийн орлогоо нэмэгдүүлэх хүэлтэй эмэгтэйчүүд.

Аж ахуйн нэгж, байгууллага:

- 2.7. Мэргэжлийн сургалтын байгууллага;
- 2.8. Ажил олгогч байгууллага.

Гурав. Хэрэгжүүлэх зарчим, удирдлага зохион байгуулалт

- 3.1. Хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага холбогдох арга хэмжээнд хамрагдахаар хандсан иргэнд хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээ (профайлинг) хийж, тэдгээрийн онцлог хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр хөтөлбөрт хамруулна.
- 3.2. Ажил, мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ, мэдээллийг хүргэх, ажил, мэргэжлээ сонгох болон хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах нөхцөлийн талаар зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах, ажилд зуучлах ажлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу үзүүлнэ.
- 3.3. Хөтөлбөрийг удирдлага арга зүйгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, нэгдсэн зохицуулалтаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, зохион байгуулалтаар хөтөлбөрт нэр дурдсан харьяа байгууллагууд хангаж ажиллана.
- 3.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгдсэн удирдамж болон холбогдох үйл ажиллагааны зардлын жишиг хэмжээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд батална. Удирдамжид арга хэмжээний нарийвчилсан зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналт, хамрагдах иргэн, аж ахуйн нэгж байгууллагад тавигдах шалгуур, үзүүлэлтийг тодорхойлж, арга хэмжээний үйл явц, үе шат, үр дүн, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага болон бусад шаардлагатай зохицуулалтуудыг тусгасан байна.
- 3.5. Хөтөлбөрийн холбогдох арга хэмжээний тайлангийн маягт болон арга хэмжээ тус бүрийг хэрэгжүүлэхэд шаардагдах гэрээнүүдийн жишиг загварыг Хөдөлмөр,

халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга батална. Тайлангийн маягтад хөтөлбөрт дурдсан арга хэмжээ тус бүрд хамрагдсан иргэний мэдээлэл, үр дүн, зарцуулсан хөрөнгийн хэмжээг нарийвчилсан байдлаар тусгах бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны саналыг үндэслэн батална.

- 3.6. Энэ хөтөлбөрт тусгасан санхүүгийн дэмжлэгийг Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ын хүрээнд хэрэгжүүлж, зохион байгуулна.

Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээ

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн зах зээлд эргэн нэвтрэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор ажиллах хүчнээс гадуур байгаа эмэгтэйчүүдийг хөдөлмөр эрхлэхэд тулгарч буй бэрхшээлийг арилгаж, тэдэнд болон гэртээ удаан хугацаагаар хүүхдээ харж буй бага насны хүүхэдтэй ээжүүдэд хөдөлмөрлөх боломж олгох хүрээнд дараа арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.1. Хүүхэд харах үйлчилгээний төв байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх⁹

- 4.1.1 Хүүхэд харах үйлчилгээ зохион байгуулах, эрхлэхийг хүсч байгаа иргэнд хүүхэд харах үйлчилгээний хуулийн дагуу эрх бүхий байгууллагаас хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авч, хэрэгжүүлэх боломжтой талаар мэдээлэл өгнө.
- 4.1.2 Хүүхэд харах үйлчилгээний төв байгуулах хүсэлтэй, Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль тогтоомжийн шаардлагыг хангасан, энэ хөтөлбөрийн 2.1-2.6-д заасан иргэний боловсруулсан төслийг хэрэгжих үндэслэлийг харгалзан шалгаруулж, 10.0 хүртэл сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийг 36 сарын хугацаатайгаар нэг удаа олгоно.
- 4.1.3 Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь жил бүрийн 4 болон 9 дүгээр сард төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ба санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлт гаргасан иргэдийг бүртгэн төслүүдийг хүлээн авч сонгон шалгаруулна.
- 4.1.4 Төсөл нь энэ хөтөлбөрийн 2.1-2.6-д заасан 2 буюу түүнээс дээш иргэнийг ажлын байраар хангах зорилготой байх нь төслийг сонгон шалгаруулах давуу тал болно.
- 4.1.5 Төслийг аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын даргын тушаалаар байгуулсан ажлын хэсэг шалгаруулах ба сонгон шалгаруулалтын үе шат бүрийг ил тод, нээлттэй иргэдийн оролцоог хангасан байдлаар зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд төслийн санал ирүүлсэн иргэн өөрийн төслийг ажлын хэсэг болон ажлын хэсгийн үйл ажиллагааг хянаж байгаа иргэдийн төлөөлөлд танилцуулж болно.
- 4.1.6 Санхүүгийн дэмжлэг авахаар шалгарсан иргэнтэй тухайн аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага гэрээ байгуулж, эргэн төлөлтийг хариуцан ажиллана.

4.2. Хүүхэд харах төвд түрээсийн дэмжлэг үзүүлэх

- 4.2.1 Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага эрх бүхий хүүхэд харах үйлчилгээ үзүүлэгчид хүчин чадал, нөхцөл боломж, хэрэгцээ шаардлагыг нь

⁹ Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн иргэн, аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний жишгээр олгоно.



харгалзан тухайн жилийн 6 хүртэл сарын хугацааны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт¹⁰ийг төлбөрийн дэмжлэг үзүүлнэ.

4.2.2 Эрх бүхий хүүхэд харах үйлчилгээ үзүүлэгч 6 болон түүнээс дээш сарын хугацаагаар ажлын байр түрээслэн үйл ажиллагаа явуулж байсан байх шаардлагатай бөгөөд түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг холбогдох баримт бичиг, түрээсийн гэрээ, түүний төлбөрийг төлсөн баримтыг үндэслэн нөхцөл байдлыг газар дээр нь үнэлгээ хийж, тодорхойлсны үндсэн дээр улиралд нэг удаа нөхөн олгоно.

4.2.3 Ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг авсан иргэн, аж ахуйн нэгж тухайн ажлын байрыг хадгалах үүрэг хүлээх бөгөөд энэ тухайг холбогдох гэрээнд тусгаж, зохион байгуулагч талтай байгуулна.

4.3. **Богино хугацааны ур чадвар олгох, гэрээс болон зайнаас ажиллахыг дэмжих сургалт**

4.3.1 Хөдөлмөрийн зах зээлийн болон ажил олгогчийн эрэлтэд нийцүүлэн хөдөлмөр эрхлэх ур чадварт хийсэн үнэлгээнд үндэслэн мэргэжлийн болон цахим ур чадварыг богино хугацаанд эзэмшүүлэх хөдөлмөр эрхлэлтийн хосолсон (танхим, цахим) сургалтыг зохион байгуулна:

4.3.1.1 Цахим ур чадвар эзэмшүүлэх;

4.3.1.2 Мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх;

4.3.1.3 Хувь хүний хөгжил, харилцааны ур чадвар дээшлүүлэх.

4.3.2 Хөтөлбөрийн 4.3.1.2-т заасан мэргэжлийн сургалтыг Хөдөлмөрт бэлтгэх сургалтын хөтөлбөрийн 4.2-т заасан хөдөлмөр эрхлэлтийн сургалтад нийцүүлэн зохион байгуулна.

4.3.3 Хөтөлбөрийн 4.3.1.1, 4.3.1.3-т заасан сургалтыг холбогдох сургалтын хөтөлбөрөөр зохион байгуулах бөгөөд үргэлжлэх хугацаа 2 долоо хоног хүртэл, 7 хоногт 20 цагаас доошгүй цагийн хөтөлбөртэй байна.

4.3.4 Хөтөлбөрийн хамрах хүрээнд заасан эмэгтэйчүүд 2 хүртэлх сургалтад хамрагдаж болох бөгөөд аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага гэрээний дагуу сургалтад бүрэн хамрагдсан байхад анхаарна.

4.4. **Цагаар ажиллахыг дэмжих**

4.4.1 Аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага хүүхэд асран хамгаалах үйлчилгээнд хамрагдсан цагаар ажил эрхлэх хүсэлтэй ээжүүдийн бүртгэл, судалгааг хийнэ.

4.4.2 Ажил олгогчдоос цагийн ажлын байрны захиалгыг авч, уулзалт зохион байгуулж, мэдээ, мэдээллээр хангаж ажиллана.

4.4.3 Цагийн ажилд зуучлах өдөрлөг зохион байгуулж, аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага хүүхэд асран хамгаалах үйлчилгээнд хамрагдсан ээж, ажил олгогчтой гурвалсан гэрээ байгуулна.

4.4.4 Хүүхэд асран хамгаалах үйлчилгээнд хамрагдсан ээжүүдийг /ажилтан/ цагийн ажлын байраар хангасан ажил олгогчид гэрээний хугацаанд ажлын байранд сургаж, дадлагажуулсан зардлыг үйлдвэр дээрх сургалтын зардлын доод хэмжээгээр тооцож холбогдох баримт бичгийг үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нөхөн олгоно.

4.4.5 Гэрээний хугацаа нь 6 сараас хэтрэхгүй байна.

4.5. **Хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ**

¹⁰ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан "Түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх нэг сарын зардлын хэмжээ"-нээс хэтрүүлэхгүй байна.

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбоотой бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран ажиллана.


- 4.5.1. Хөдөлмөрийн тухай хуулийг сурталчлах, хэрэгжилтэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх;
- 4.5.2. Холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай дараах чиглэлийн хүрээнд хамтран ажиллах;
- 4.5.3. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой судалгаа хийх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний санал боловсруулах;
- 4.5.4. Ажлын байранд хүүхэд саатуулах өрөө байгуулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх;
- 4.5.5. Зайнаас болон гэрээс ажиллах уян хатан нөхцөлөөр хангахад арга зүйн дэмжлэг үзүүлэх;
- 4.5.6. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн сайн жишээг түгээн дэлгэрүүлэх, нөлөөллийн ажил зохион байгуулах;
- 4.5.7. Ажилгүйдлийн болон хөдөлмөрийн зах зээлд эргэн нэвтрэхэд чиглэсэн сэтгэлзүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх;
- 4.5.8. Эмэгтэйчүүдийн ажлын байрны бэлгийн дарамттай холбоотой судалгаа хийх, мэдээллийн санг сайжруулах;
- 4.5.9. Гэрээс болон зайнаас ажиллах боломжтой ажлуудыг ажил олгогчид таниулах ажил зохион байгуулах;
- 4.5.10. Бусад үйл ажиллагаа.

Тав. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн

Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар гаргахаас гадна хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага нь бүх шалгуур үзүүлэлтийг нас, хүйс, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр тус бүрээр нарийвчлан гаргаж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд сар бүр тайлагнана.

5.1. Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт

Түвшин	Үзүүлэлт	Баталгаажуулах эх сурвалж	Суурь түвшин (2021)	Хүрэх түвшин (2022)	Хүрэх түвшин (2023)
Гарцын шалгуур үзүүлэлт (output)	Хүүхэд харах үйлчилгээний төв байгуулах санхүүгийн дэмжлэг авсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо, зарцуулсан болон эргэн төлөгдсөн хөрөнгийн хэмжээ,	ХХҮЕГ-ын сарын, жилийн тайлан	-	33 төв	33 төв
	Мэргэжлийн болон цахим ур чадварын сургалтад			890 иргэн	900 иргэн

	хамрагдсан, чадамжийн гэрчилгээ авсан эмэгтэйчүүдийн тоо				
	Цагийн ажилд хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо, цагийн ажлын төрөл, салбар бүрээр, зарцуулсан хөрөнгө			31 өдөрлөг 540 иргэн	
	Түрээсийн дэмжлэг авсан төвүүдийн тоо			150 төв	160 төв
Үр дүнгийн шалгуур үзүүлэлт (outcome)	Хөтөлбөрт хамрагдсанаар байнгын болон цагийн (цахим) ажлын байртай болсон эмэгтэйчүүдийн тоо	Хөтөлбөрт хамрагдахаас өмнөх суурь түвшинтэй харьцуулсан судалгааны тайлан (хөтөлбөр хэрэгжиж дууссанаас хойш 1 жилийн дотор)		Хөтөлбөрт хамрагдах үеийн нөхцөл байдлын мэдээлэл	Суурь мэдээлэл дээр үндэслэн нэмэгдсэн ажлын байрны тоо